

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-5
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	6-47
<b>1.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	7-10
<b>2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</b>	10-11
<b>3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</b>	11
<b>4.Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл</b>	11-47

---

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 04 дүгээр сарын 16-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 02 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяа, Г.Амартүвшин, Э.Бат-Амгалан, С.Бямбацогт,  
Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд, Б.Энх-Амгалан;  
Тасалсан: Н.Алтанхуяг.

**Нэг.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**1 дүгээр зүйл.** Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 10 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 12 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. Байнгын хорооны тогтоолын төсөл** /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүн Д.Ганбат ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./12:22/

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан эрх зүйн дүн шинжилгээ гаргуулах талаар горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 12 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Цогтбаатар:** “Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 12 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.*

**Дөрөв.Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын гишүүн Ж.Хунан, М.Мөнхзул, Г.Нарантуяа, Б.Энхболд, Тамгын газрын дарга Ц.Адьяахишиг, Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга З.Өнөржаргал, Хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга Х.Цэцгээ, Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Ариунаа, Хүний эрхийн боловсрол хариуцсан референт О.Тодбулаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны ахлах мэргэжилтэн Г.Чингүүнжав нар байлцав.

1.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн “Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт, нөхцөл байдал” болон “Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал” сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид танилцуулга хийв.

“Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт, нөхцөл байдал” болон “Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал” сэдвээр хийсэн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн “Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт, нөхцөл байдал” болон “Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал” сэдвээр хийсэн мэдээллийг сонсов.

2.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн “Хүүхдийн эрхийн зарим асуудал” сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ж.Хунан, “Гэр бүлийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал” сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул нар танилцуулга хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн “Хүүхдийн эрхийн зарим асуудал” болон “Гэр бүлийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал” сэдвээр хийсэн мэдээллийг сонсов.

3.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн “Иргэний нийгэм болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилт” сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга З.Өнөржаргал танилцуулга хийв.

“Иргэний нийгэм болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилт” сэдвээр хийсэн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн “Иргэний нийгэм болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилт” сэдвээр хийсэн мэдээллийг сонсов.

4.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн “Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн хэрэгжилт” сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Энхболд танилцуулга хийв.

“Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн хэрэгжилт” сэдвээр хийсэн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн “Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн хэрэгжилт” сэдвээр хийсэн мэдээллийг сонсов.

5.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс, шийдэл” сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Г.Нарантуяа танилцуулга хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс, шийдэл” сэдвээр хийсэн мэдээллийг сонсов.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 33 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 35 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
12 цаг 02 минут.

### ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Байнгын хорооны дарга Цогтбаатар, Дашдондогийн Ганбат гишүүн, Цэндийн Мөнх-Оргил гишүүн, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн, Цэдэвийн Сэргэлэн гишүүн, Ням-Осорын Учрал гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Баттөмөрийн Энхбаяр гишүүн гэсэн ирцтэйгээр ирц бүрдсэн байна. Ингээд хурал эхэлж байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж ийнхүү дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын 19 гишүүн 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл байгаа. Анхны хэлэлцүүлэг.

Хоёрдугаар асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл “Цаглавар батлах тухай”.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр ирүүлсэн Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн дараах сэдвийг хэлэлцэх. Үүнд:

Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт, нөхцөл байдал;

Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал;

Хүүхдийн эрхийн зарим асуудал;

Гэр бүлийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал;

Иргэний нийгэм болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилт;

Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн хэрэгжилт;

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс, шийдэл.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрсээ өгнө үү. Хэлэлцэх асуудалтай холбоотой санал. Та хэлэлцэх яг асуудал дээрээ тийм.

Хэлэлцэх асуудлаар санал хэлэх гишүүд байхгүй байна. Ингээд хэлэлцэх

асуудлаа баталлаа. Хэлэлцэх асуудалдаа орё.

**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Төгөлдөр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга. Хариуцаж байгаа гишүүн нь Улсын Их Хурлын дэд дарга Одонтуяа байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн I дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. Энэ дээр I санал байгаа. Энэ үү тээ? Энэ дээр I санал байгаа. Энийг би уншиж танилцуулъя. Байнгын хорооны анхны хэлэлцүүлэгт бэлдсэн байгаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн I дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

I дүгээр зүйл. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Санал гаргасан, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар, Сандаг-Очир. Ингээд санал хураалт явуулъя. Энэ саналтай холбогдоод асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Сүхбаатар гишүүн байна. Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

**Ж.Сүхбаатар:** Гишүүдийнхээ өдрийн мэндийг хүргэе. Төсөл дээр бол 24 оны 12 сарын 31-нээс хойш бол цагаатгах тухай гомдлыг хүлээж авахгүй гээд ийм хугацаа заачихсан. Уг нь зөв, зүйтэй л ийм санал байх шиг байгаа юм. Ер нь бид нар сүүлийн энэ 26 жил чинь ийм хоёр л асуудал ярьсан шүү дээ. Энэ хэзээ дуусах юм бэ гэдэг. Цагаатгаад мөнгө олгох нь хэзээ дуусах юм бэ? Дээр нь цагаатгалын ажлыг хэдий хүртэл үргэлжлүүлэх юм бэ гэдэг. Тэгээд жил болгон л ингээд мөнгө олох асуудал сунгагдаж явсаар байгаад гол хүмүүс маань бол мөнгөө авчихсан гэж ойлгож байгаа. Зүгээр бичиг баримтын хувьд олдохгүй байгаа, зөрчилтэй байгаа, тогтоогдож өгөхгүй байгаа гэдэг шалтгаанаар хохирсон гэдэг тодорхой иргэд байдаг гэж ойлгож байгаа. Тэд нар тодорхой хэмжээнд мөнгөө авч чадахгүй үлдсэн байгаа байх.

Тэгэхээр одоо цагаатгалын ажлын үйл явц цаашаа ингээд сунгахад гол үндэслэл хэрэгтэй л дээ. Сая хугацаа тавьчихсан байгаа нь би уг нь ингээд бид нар жилийн жилийн парламентад ярихдаа бол шахаад явах нь зүйтэй гээд хугацаа тавиад байсан. Тэгэхээр Цогтбаатар дарга өөрөө ингээд санаачлаад орж ирж байгаа хугацаагүй байлгая гэж байна шүү дээ. Энэ ингээд хугацаагүй байлгая гэхээр чинь энэ хууль маань хэд хэдийд дуусахгүй ингээд л үргэлжилсээр байна, комисс



үргэлжилсээр ажиллана гэж ойлгож болох уу? Комисс? Энэ комисс чинь бас төрийн байгууллага, цалин цавуу төсөв авдаг. Энэ чинь хязгааргүй үргэлжлээд ингээд явах уу, яах вэ? Энэ чинь 80, 90 жилийн өмнө болчихсон, 70 жилийн өмнө болсон, бид нарын эргэн тойрныхон бас ингээд гомдол санал нь барагдаад явж байдаг. Мэдээж хэрэг цаана нь байгаа цөөн ч гэсэн иргэдийн төлөө Монголын төр ажлаа явуулах ёстой.

Гэхдээ үндэслэл байх ёстой шүү дээ. Та жишээлбэл яагаад бодоод хугацаагүй байлгая гэдэг ийм санал гаргаж байгаа юм бэ? Дараа дараагийн парламент үүнийг хэлэлцэхгүй байх нь байна шүү дээ. Энэ чинь хугацаандаа баригдаад л уг нь овоо яригдаад байдаг. Юу болов, яав ийв гэдэг байсан. Ингээд хугацаагүй тавиад хэзээ ч юм уу ингээд л дуусахгүй явах юм уу? Энэ нь зөв юм уу, буруу юм уу? Уг нь аль 8-12 онд намайг ажиллаж байхад л бас л энэ яриа болж л байсан юм. 20 жил болчихлоо. Яах юм, ийх юм гээд л. Ингээд л удахгүй дуусах юм л гэж байсан юм. Миний сайн санаж байгаагаар. Тэрнээс хойш дахиад 10 хэдэн жил өнгөрчихлөө л дөө. Дахиад дуусах болоогүй гэсэн. Ер нь бол энд тийм үндэстэй энэ цагаатгалын комиссын дарга энд сууж байна өөрөө. Энэ үндэстэй тайлбар хэрэгтэй байна л даа. Мэдээж Монголын төр бол нэг ч гэсэн иргэнийхээ эрх ашгийг хөсөрдүүлэхгүйн тулд ажиллах ёстой гэдгийг ойлгож байгаа.

Гэхдээ бидэнд учир шалтгаан, хугацаа, энэ төсөв мөнгөтэй холбоотой асуудлууд дээр бас тодорхой тайлбар хэрэгтэй байгаа.

**Д.Цогтбаатар:** Би, та дараа нь бас хариулчхаарай.

Сүхбаатар гишүүн яг чухал асуулт асууж байна. Яг энэ дээр асуудал юу вэ гэхлээр Комиссын тухай биш, гомдол гаргах тэр эрхийн тухай. Гэтэл та ингээд бод доо хэдүүлээ ингээд хугацаа тавиад өгчихлөө. Энэ чинь 37 онд

болсон юмыг тэр 100 жилийн дараа болгож болж байснаа одоо нэг хугацаа тавьж өгөөд, 1 жилийн дотор энд хэтэрхий урт хугацаатай байх гээд байна гээд. Тэгтэл гарсан тэр гэмт хэрэг хилс хэрэгт хүнийг хамруулаад, амийг нь бүрэлгээд, гэр бүлийн төлөө ингээд тэр үйлдэл бол өөрөө угаасаа мартаж болохгүй. Дэндүү ноцтой, дахиад давтагдаж болохгүй хэргийн тухай бид нар ярьж байна шүү дээ.

Тэгэхлээр энэ дээр юу яригдаж байна гэхлээр бараг зуугаад жилийн дараа энийг сэргээж болж байгаа байж одоо энэ дээр 1 жил, 2 жил ингээд үргэлжлээд явах гэхлээр энэ урьджиж байна гэхлээр уг нь логик талаас асуудал байгаа юм.

Хоёрдугаарт, хамгийн миний санаа зовж байгаа юм энд чинь материал нь олдохгүй, бас энэ чинь нэлээн удчихсан хэргүүд болохлоор нөхцөл нь бүрдэж өгөхгүй явж байгаад 1 хүн олоод ирсэн чинь тэр хугацаа нь дуусчихсан байвал тэр хүмүүс дэндүү хохиролтой болчихож байгаа байхгүй юу. Тэгэхлээр би тэр гомдол гаргах хугацааг нь нээлттэй үлдээгээд өгчихье. Тэр дээрээ хүмүүс хэзээ юм нь бүрдээд ирнэ. Яг үнэндээ юм нь бүрдэхгүй байгаа бол угаасаа тэр нөхцөл нь бүрдэхгүй, асуудал шийдэгдэхгүй шүү дээ. Тэгэхлээр тэр өнцгөөс нь л иргэддээ илүү ээлтэй байх өнцгөөс би энийг хугацаагүй байлгах нь зөв гэж бодож байна. Угаасаа та өөрөө мэднэ шүү дээ. Ер нь олон улсын хуульд жишээлбэл, ... норм гээд байдаг юүс коженс гээд Хүн төрөлхтний жишээлбэл эсрэг гэмт хэрэг бол ямар ч, угаасаа хугацаагаар хязгаарлагддаггүй байдаг. Тэр өнцгөөс нь л ярьсан юм.

Одонтуяа гишүүн бас нэмээд хариулчихъя.

**С.Одонтуяа:** Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ заалтаар зөвхөн шүүхэд өргөдөл гаргах хугацааг л хугацаагүй болгоё гэсэн гишүүдийн саналыг дэмжиж байгаа юм.

Тэр нөхөх олговор олгохтой холбоотой заалт бол нэмэлт, өөрчлөлтөөр хөндөгдөөгүй. Ер нь одоо бараг төрсөн хүүхэд нь л авна гэсэн энэ нөхөх олговрын заалтаар төрсөн хүүхэд нь ихэнх нь өргөдлөө өгөөд асуудлаа шийдүүлэх нь шийдүүлчихсэн. Одоо бол бараг ач, гуч нар нь 60, 70 хүрчээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр төсөвт ямар ч ачаалал гарахгүй. Одоо хэд хэдэн чухал шийдэгдээгүй асуудал байгаа.

Нэгдүгээрт, одоо бид нар харь оронд бас хэлмэгдсэн хүмүүсийн материалыг нааш нь татаж авчирч нэр төрийг нь сэргээх асуудал дутуу байна. Дээрээс нь одоо Тагнуулын ерөнхий газар байгаа тэр тусгай архивд материалтай нь танилцаж байгаа маш олон хэргүүд байж байгаа. Өргөдлөө гаргая бид нар цагаатгуулах нь чухал байна, бид нар тэр мөнгө төгрөг тэр ерөөсөө хамаагүй гэсэн бүхэл бүтэн үзэмчин ястны хүмүүс олон хүн байнга тэр хүмүүс ингээд ерөөсөө л цагаатгуулахын төлөө тэд төрийн бус байгуулаад ингээд олон жил яваад байгаа. Тэгэхээр энэ төрлийн олон асуудлууд үлдчихсэн байгаа учраас Их Хурал дээр орж ирээд л байнга жил болгон хугацаа сунгаад байх нь өөрөө утгагүй юм гэсэн.

Одоо 1943 оны 4 дүгээр сарын 3-нд Чэжүд маш том ийм хэлмэгдүүлэлт болсон. Энэний асуудал хүртэл ерөөсөө ингээд ДНК-ийн шинжилгээгээр хүртэл ингээд л хүмүүсийг нь тодорхойлоод л, нэр төрийг нь сэргээгээд л ингээд л яваад байгаа юм л даа. Энэ өөр их бас их урт процесс юм билээ. Тэгэхээр энэ дээр яг Цогтбаатар гишүүний хэлдэг хуулийн асуудал нэг өөр, өргөдөл, гомдол авах хугацаа нэг өөр, тэр комиссын ажил нэг өөр. Комисс гээд хэдхэн л хүн байдаг юм л даа. Бүх л энэ гол нь бас энэ соён гэгээрүүлэх ажлууд дээр нэлээд анхаараад ингээд явж байгаа. Тэгэхээр энэ бол дараагийн асуудал байх. Ажлын тэр ачааллаасаа, хэдэн хүн дахиж өргөдөл, гомдол гаргаж байна. Шүүхээр л шийдүүлчихдэг юм.

Тийм болохоор энэ ганцхан хугацаа сунгах дээр л гишүүд саналаа хэлсэн нь зөв байх аа.

**Д.Цогтбаатар:** Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

**Ж.Сүхбаатар:** Ямар ч байсан тайлбарыг сонслоо. Тэгэхээр нэг ийм асуудал байна. Тэр бид нар ч гэсэн ингээд байхад манай тойрог дээр надтай уулзаад л, бичиг баримт олдохгүй уг нь ингээд хохироод ингээд хэлмэгдчихсэн юм байгаа юм энэ асуудлыг ингээд шийдэж өгч болохгүй ингээд архиваас нь үзэхээр ингээд гаргаж өгч чадахгүй байна гээд ингээд хохироод байх юм гээд.

Тэгэхээр нөгөө талдаа Цагаатгалын комиссын талаас асуумаар байгаа юм. Үгүй ээ энэ хугацаагүй яах вэ болгодог нь ингээд зөв байна. Ингээд бид ингэж байна. Энэ архиваас олдохгүй бичиг баримт олдохгүй байгаа хүмүүсийг чинь тэгвэл нэгэнт олдохгүй байх нь ойлгомжтой шахуу болчихоод байгаа улсуудын юмыг тэгвэл яаж тогтоох юм бэ? Энд чинь дараад жилийн дараа шинэ баримт үүсэхгүй шүү дээ бичиг цаас. Тэгэхээр энэ улсуудыг цэгцлэх, энэ улсуудын эрх ашгийг хамгаалах талаар Цагаатгалын комисс ямар бодлого баримталж байгаа юм? Одоо тэр гомдол гаргаад байгаа хүмүүс ч бидэнд ингээд л хүсэлт тавих юм. Одоо бид нар чинь тэрийг чинь ямар нөхөөд олгуулж чадах юм биш. Тэгээд л асуудлаа тавьж байгаа. Мэдээж зарим нь та нарт тавь.../минут дуусав./

**Д.Цогтбаатар:** Одонтуяа гишүүн хариулах уу? Анхан, Төгөлдөр даргын микрофон 1 дүгээр микрофон өгье.

**Г.Төгөлдөр:** Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр иргэдээс өргөдөл гомдол хүлээн авах хугацааг онгойлгож өгснөөр шүүхэд иргэд янз бүрийн нөхцөл байдалд хүнээ алдсан болон цаазаар авхуулсан, шоронд хоригдсон гэсэн энэ янз бүрийн өргөдлүүд ирэх юм.

Тэгэхээр энд шүүхийн процессын үйл ажиллагаа нь хуульд заагдсанаараа энэ 8 дугаар зүйлд заагдчихсан таны түрүүний асуудаг сураггүй алга болсон ямар ч баримт бичиг олдохгүй гэсэн энэ зүйл, заалтуудыг тухай бүрчлэн хуульдаа оруулсан. Нутгийн хоёроос дээш хүн баталсан, эс үгүй бол ямар нэгэн байдлаар баривчилсан, саатуулсан гэсэн ийм баривчилсан саатуулсан гэсэн нэг ч болсон ийм цаас олдсон энэ тохиолдолд шүүхээс тэрийг хэлмэгдүүлсэн гэж тооцож цагаатгах буюу эс үгүй бол хэрэгсэхгүй болгох ийм 2 төрлийн шийдвэрийг гаргаад явж байгаа. Тэгэхээр бусад 8 дугаар зүйлд заагдсан энэ зүйл ангиудыг шалгах боломж нь нээгдэнэ гэсэн үг.

**Д.Цогтбаатар:** Тийм. Сүхбаатар гишүүнээ яг энэ дээр үнэхээр нэг ийм юм хэдүүлээ бас хандлагын нэг асуудал байгаа юм. Юу вэ гэхлээр ийм хэрэг дээр төр өөрөө хугацаа зааж хаадаг байж болохгүй юм. Яагаад гэхлээр та сая яг хэлж байна шүү дээ. Архивын материал олдохгүй гэдэг чинь техникийн асуудал байгаа. Техникийн асуудлаар энийг ингээд хэдүүлээ хаах гээд. Олдвол яах вэ? Энэ олдох магадлал ч бий шүү дээ. Жишээлбэл, Монголын архив биш, гаднын архивуудаас сая яг Одонтуяа гишүүн манай аягүй олон хүн гадагшаа архивуудад явж ажилладаг байхгүй юу. Өнөөдөр байхгүй байгаа материал маргааши олдохыг ёстой хэн ч хэзээ ч үгүйсгэх боломжгүй нэг.

Хоёрт, миний бодож байгаагаар бол гомдол гаргаад байгаа хүмүүс чинь бодит хохирсон хүмүүсээсээ цөөхөн байгаа шүү. Цаанаа дуугараагүй, дуугарах хүнгүй болчихсон ер нь хохирчихсон хүмүүс ч зөндөө. Тэгэхлээр би энэ дээр төрийн хандлага бол иргэдийнхээ өмнө тийм нүгэл үйлдсэн бол энийг төр нь лав өөрөө хаадаг байж болохгүй. Тэгж төрд тийм тааламжтай нөхцөл үүсгэж болохгүй. Нүгэл бол нүгэл. Тэрний хариуцлагыг иргэдийнхээ өмнө

хүлээдэг байх ёстой л гэж би бодож байгаа.

Тэгвэл энэ дээр асуулт, хариулт явж дууслаа. Тэгэхлээр сая энэ томъёоллыг уншиж танилцуулсан. Энэ саяын уншиж танилцуулсан томъёоллоор саналыг дэмжье гэж санал хураалт явуулъя.

60 хувиар санал дэмжигдлээ.

Ганбат гишүүн дэмжсэн байна. Ганбат гишүүнийг дэмжсэнээр протоколд оруулаарай машин ажиллаагүй байна. Ингээд хоёр дахь асуудал руугаа оръё.

12.21 цаг

**“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.**

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Болно. Та тийм Ганбат гишүүн саналтай гэсэн. Ганбат гишүүнд микрофон өгье. Тэгье, дараа нь та тэгвэл хэлчих тэгье. Микрофонд хэлээд хэрэггүй, би оруулчихъя. Ганбат гишүүний микрофон.

**Д.Ганбат:** Энэ Үндсэн хуулийн цэцтэй холбоотой 2 хууль орж ирж байгаа. Энэ дээр одоо 1 л ажлын хэсэг байгуулж байгаа нь ямар байна вэ гэсэн ийм зүйлийг манай Ардчилсан намын бүлэг дээр ярьж байгаа. Тэгээд хэд хэдэн Үндсэн хууль зөрчсөн зүйл, заалтууд байна. Энэ хуулийн төсөл дээр.

Ийм учраас бид бүхэн бас дүгнэлт гаргуулах гээд хандчихсан байгаа Улсын Их Хурлын Тамгын газарт. Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4-д заасны дагуу нэгдсэн болон байнгын хорооны хуралдааны үед хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах. Тийм учраас Ардчилсан намын бүлэг 5 хоногийн завсарлага авъя гэсэн ийм хүсэлтийг гаргаж байна.

**Д.Цогтбаатар:** Тэгвэл ажлын 5 хоногийн завсарлага олголоо.

Хууль зүйн яамнаас гаргаж байгаа саналыг бид нар бас боловсруулах тэгвэл саналдаа тусгана. Энэтэй холбогдуулаад энэ бас би Хууль зүйн байнгын хорооны гишүүний хувьд, даргын хувьд энэ хэлэлцэж буй асуудалтай холбогдуулаад хууль зүйн бас дүгнэлт гаргуулъя гэдэг ийм санал гаргаж байгаа энийг ингээд бас тэмдэглээд, энэ дээр хууль зүйн дүгнэлт гаргая, эрх зүйн дүгнэлт гаргая гэдэг санал хураалт явуулъя. Энэ би гишүүний, Байнгын хорооны даргын хувьд бас гаргаж байгаа санал байгаа юм. Санал хураалт.

60 хувиар дэмжигдлээ санал.

Улсын Их Хурлын Тамгын газарт үүгээр эрх зүйн дүгнэлт гаргах чиглэл өгч байна. Гурав дахь асуудалдаа орёё.

**“Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.**

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү.

Байхгүй байна. “Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

70 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн асуудалдаа орёё.

12.24 цаг

**Монгол Улсын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 23 дахь илтгэлийг хэлэлцье**

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай байдлын талаарх 23 дахь илтгэлийн талаар товч танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Дугарын Сүнжид танилцуулна. Ажлын хэсгээ танилцуулах уу? Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Энхболд, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Мөнхзул, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Нарантуяа, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын Тамгын газрын дарга Адьяахишиг, Хүний эрхийн Үндэсний Комиссын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга Тунгалагтамир, Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга Өнөржаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх, боловсролын хэлтсийн дарга Цэцгээ, Хүний эрхийн Үндэсний Комиссын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн

ахлах референт Ариунаа, Хүний эрхийн Үндэсний Комиссын эрхийн боловсрол хариуцсан референт Тодбулаг гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг энэ хуралд оролцож байна.

**Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн нөхцөл, Сүнжид дарга асуудлаа танилцуулна.**

Сүнжид даргын микрофоныг өгье.

**Д.Сүнжид:** Эрхэм та бүхэнд энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 23 дахь илтгэл нь 7 бүлгээр бичигдсэн. Энэ нь бид нар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7.1.12, 9 дүгээр зүйлийн 1, 17.1 дэх хэсэгт заасны дагуу жил бүр тухайн жилд тулгамдсан хүний эрхийн асуудлаар тулгамдсан асуудлыг сонгож авч бичдэг илтгэл.

Энд заасан хуульд заасны дагуу 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд хүргүүлсэн. Энэхүү илтгэлийг 7 бүлгээр бичсэн.

Нэгдүгээрт нь Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт нөхцөл байдал.

Хоёрт нь Боловсролын салбар дахь хүний эрхийн хэрэгжилт, нөхцөл байдал.

Гуравдугаарт нь Хүүхдийн эрхийн зарим асуудал. Хагас, бүтэн өнчин хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаарддаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн асуудал.

Гэр бүлийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлын асуудал дөрөв дэх сэдэв.

Тав дахь нь Иргэний болон байгаль орчны чиглэлээр хүний эрх

хамгаалагчдын эрхийн хэрэгжилтийн асуудал.

Зургаа дахь нь Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм эдийн засгийн, соёлын эрх.

Ингээд долоо дахь нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцооны асуудал гээд 7 сэдвийн хүрээнд боловсруулж, нийтдээ 54 саналыг энэ 7 сэдвийн хүрээнд санал болгож Улсын Их Хуралдаа энэ тогтоолд оруулахаар Комиссоос уламжлаад байна.

Нэгдүгээр сэдвийн хүрээнд Цогтбаатар дарга шууд танилцуулаад явчих уу? Эхний сэдвээ.

**Д.Цогтбаатар:** Тэг тэг шууд танилцуулаад явчих.

**Д.Сүнжид:** Нэгдүгээр сэдэв нь Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт, нөхцөл байдал. Энэ 4 асуудлыг хамарч, дэд сэдвийн хүрээнд бичигдсэн юм.

Юун түрүүн хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил ямар байгаа вэ гэдгээр дүгнэлт хийсэн. Тэгэхээр 30 орчим хууль, энэ байгаль орчны салбарт үйлчилдэг юм байна. 200 орчим стандарт захиргааны хэм хэмжээний акт, дүрэм журам үйлчилдэг. Энд хүний эрхийн үүднээс нь давхардал, хийдэл, зөрчил ямар байгаа вэ гэдгийг авч үзсэн. Ингээд нийтдээ давхардал байгаа учраас 90, 96 ийм давхардал, зөрчил байгаа учраас үүнийг хуульд нийцүүлж, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хэрэгжилтийг хангах үүднээс энийг сайжруулах, боловсронгуй болгох нийцлийг хангах шаардлагатай байна гэдэг нэгдүгээр дэд сэдвийн хүрээнд авч үзлээ.

Хоёрт нь Орчны бохирдлын асуудал 3-ийн хүрээнд агаар, ус, хөрс гээд. Агаарын бохирдлын хэмжээг харахаар бид нар сүүлийн 10 жилд энэ

азотын хүчил, хүхрийн хүчил давхар исэл, тэгээд хүхэрлэг хий, 2.5, 10 гээд тоосонцруудын хэмжээ ялангуяа өвлийн улиралд түүхий нүүрс түлдэг цагаар 2-7 дахин их байна гээд. Үүний үр дүн нь юун дээр гарч ирдэг вэ гэхээр эрүүл мэндэд тусаж байгаа байдал. Бид нар жилдээ 300 хүн энэ агаар орчны бохирдлоос болоод нас барж байна. Тэгээд хөгжлийн хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй болох эмгэгийн том үндсэн хүчин зүйл шалтгаан болж байна. 0-5 нас хүртэлх хүүхдүүдийн уушги, амьсгалын замын өвчлөлийн бас шалтгаан болж байна. Суурь өвчлөлтэй хүмүүсийн зүрх судасны өвчлөлийн бас шалтгаан болж байна гээд эрүүл мэндэд хамгийн их үр нөлөө үзүүлдэг хохирол үзүүлдэг юм байна гэдгийг судалгаа, дүн шинжилгээ харуулдаг.

Түүнээс гадна энэ түүхий нүүрсийг түлдгээс гадна насжилт өндөр машинаас гарч байгаа энэ бодис нь ногоон шатахуун, түүнээс гадна дулааны цахилгаан станцаас цөөхөн хувь гарч байна. Ахуйн орчин, ахуйн бохирдол гээд агаарын бохирдлыг үүсгэдэг бас бага хувь хүчин зүйл байна. Ингээд нийтдээ агаар орчны бохирдлыг аваад үзэхээр бид нар энэ дээр анхаарал тавихгүй бол сүүлийн 10 жил энэ нөхцөл байдал төдийлөн өөрчлөгдсөн сайжирсан дүр зураг харагдахгүй байна.

Хөрсний бохирдлын хувьд хог хаягдал, нүхэн жорлон гэдэг асуудлаас болоод бид нар ингээд 60 гаруй төрлийн халдварт өвчин үүсэж байна. Ингээд хог хаягдлын хэмжээнд хогийг ангилдаг, аюултай хог хаягдлыг булшилдаг, устгадаг ийм цэг зэм алга. Үүнээс нь болоод хөрсөнд бид нар энэ хар тугалга, хүнд металл, хүний биед ийм аюултай хорт бодисууд шингэдэг юм байна. Энэ нь эргээд усандаа, агаартаа нөлөөлөөд ингээд эрүүл мэндэд бас хохирол учруулах хэмжээнд байдаг байх нь.

Ялангуяа зуны улиралд энэ шар усны үер гэдэг юм уу, элдэв юунаас болоод борооны ус урссан, шар усны үер

зэргээс болоод энэ 60 гаруй төрлийн халдварт өвчин үүсдэг. Энэ үер хамгийн их халдварт өвчин ихэсдэг байна. Эний эсрэг бас тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна гэдгийг дүгнэсэн.

Усны бохирдлын эсрэг нийтдээ энэ ус үндэсний хэмжээнд булаг шанд ширгээж байгаа. Түүнээс гадна Улаанбаатар хотын хэмжээнд хэрэглэж байгаа усны чанарын шаардлага өөрөө бас хангадаггүй, эрүүл ахуйн шаардлагыг хангадаггүй юм байна. Түүнээс гадна зарим орон нутаг, худгуудад тэр байх ёстой агууламжийн хэмжээг нь нэг дахин зөөллөх, шүлтлэг болгох ийм арга хэмжээ авахгүй бол болдоггүй гэдэг ийм стандартыг бид нарт харуулдаг. Дахин саарал ус ашиглах гэдэг юм уу тийм тоног, менежментийг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Тэр дутмаг байна. Усны менежментийн төлөвлөгөө хангалтгүй байна гэдэг ийм дүр зургийг харуулдаг.

Усны нөөцийн төлбөр төвлөрч байгаа байдал бас хангалтгүй юм байна лээ. Энэ дээр 50 хүртэлх хувь нь л төвлөрч чаддаг. Энэ нь улсын төсөвтөө төвлөрдөг бөгөөд эргээд усныхаа менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бас зарцуулагддаггүй юм байна. Тийм учраас энийг нэг нэгдсэн менежментээр зарцуулах хэрэгтэй гэдэг ийм дүгнэлт хэлхийсэн.

Дөрөв дэх дэд сэдэв нь Хотын стандарт ба аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал байгаа юм.

Тэгэхээр хотын стандарт ба аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал байгаа. Хотын стандартаар Монгол Улсад бүртгэгдсэн 6589 стандарт мөрдөж байна. Эндээс бид нар зөвхөн жишээ татаад аваад үзэхээр сургууль, цэцэрлэгийн хувьд 241 сургууль Улаанбаатар хотын хэмжээнд шаардлага хангаагүй, стандартын шаардлага хангаагүй. 131 нь цэцэрлэг хангаагүй. Нийтдээ нийт тоглоомын талбайн 80 хувь нь стандартын шаардлага хангаагүй 803, явган хүний

замын аюулгүй байдлыг үзэхээр бас 1240 газар аюулгүй байдлын стандарт хангаагүй, шинэ байриилд баригдаж байгаа барилгуудыг аваад үзэхээр бас 382 нь хангагдаагүй гээд. Энэнээс болоод бид нар хүүхдүүдийн зам тээврийн осол, гэмтэл, өвөлдөө халтиргаа гулгаанаас болж гэмтдэг, бэртдэг байдал тэр битгий хэл амь насаа алддаг байдал гээд энэ бүгдээрээ үүсэж байгаа юм байна гээд энэ тоо баримттай нь үзүүлээд, стандартыг хангуулах хэрэгтэй байна гэдэг ийм дөрөв дэх дэд сэдвийн хүрээнд дүгнэлтийг хийж байгаа.

Тав дахь дэд сэдвийн хүрээнд Уул уурхайн нөлөөллөөс үүдээд тэнд амьдарч байгаа оршин суугчид иргэдийн эрүүл, аюулгүй орчинд бас ямар асуудал үүсдэг вэ гэхээр нэгдүгээрт нь тоосжилт ярьж байна. Хамгийн их нэрвэгддэг нь тэнд тоосжилтын асуудал, эрүүл мэндийн асуудал ярьж байна.

Хоёрт нь усны хангамжийн хүрэлцээний асуудал, усны чанарын асуудал, газрын гүн дэх ус барагдаж байгаа, нөөц нь хорогдож байгаа тухай асуудал. Ердийн худгаараа өөрсдөө бас усны ахуйн хэрэглээгээ хангаж чадах эсэх асуудал яригдаж байна. Хөрсний бохирдол, бэлчээрийн доройтлын асуудал бас яригдаж байна.

Нэмээд энэ уул уурхай дээр юу гарч ирдэг вэ гэхээр шууд үр дагавраас гадна иргэдийн байгаль орчны нөлөөллийн талаар мэдэх байдал, оролцоо өөрсдөө бас энийгээ мэдэж санал өгч байгаа байдал гээд энэ асуудал дээр анхаарал хандуулахгүй бол төдийлөн мэдээллийг бүрэн гүйцэд ойлгомжтой авч олон хуудаснуудыг тавьчихдаг учраас веб сайтаас тэрийг малчид болон тэр хавьд амьдардаг оршин суугчид боловсруулаад өөрт нь хэрэгтэйгээ ялгаж байгаад саналаа өгч байна гэж үзэх боломжгүй байна гэж ийм дүн, шинэ дүгнэлт гарсан.

Тийм учраас энэ дөрвөн дэд сэдвийн хүрээнд хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил, стандартын

хэрэгжилт, хоёр дахь дэд сэдэв нь агаар орчны бохирдол гээд хамтатгасан энэ агаар, ус, хөрсний бохирдлын эсрэг бууруулах арга хэмжээ авах ёстой.

Гуравдугаарт нь энэ стандартын асуудал, стандартыг хангуулах тухай асуудал.

Дөрөвд нь уул уурхайн бүсэд амьдарч оршин сууж буй иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах гээд энэ хүрээнд 14 саналыг Улсын Их Хуралд танилцуулж байна.

Энд нэгдүгээрт нь энэ хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгая гээд. Хоёрт нь энэ Засгийн газраас 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг баталсан 58 арга хэмжээг хэрэгжүүлсэн, 476 сая төгрөгийг зарцуулсан. Тэрбум төгрөгийг зарцуулсан.

Гэвчиг энэ дээр бид нар эргээд ингээд хэрэгжилтийг нь үнэлээд үзэхээс арга хэмжээ, хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсөвлөсөн санхүүжилт байгаа боловч эцэстээ агаарын чанар нь өөрөө сайжирсан дүр зураг төвөгтэй, хэцүү. Тэгж хэлж чадахааргүй байгаа.

Тийм учраас үүнийгээ эхлээд дахин үнэлж үзье. 2025 оноор дуусгавар болж байгаа. Үнэлээд энэнийхээ үр дүнд тулгуурлаад цаг хугацааны мөчлөгчтэй, оновчтой, хэмжигдэхүйц, биелэгдэхүйц, ач холбогдолтой гэдэг шалгуураар нь үнэлээд энэ урт, дунд, богино хугацааныхаа бодлогыг боловсруулах гэдэг ийм саналыг өгч байгаа.

Түүнээс гадна энэ агаар орчны бохирдлын асуудлыг үндэсний хэмжээнд хариуцах, бүтцийг тодорхойлж, тогтвортой ажиллах ийм боломжийг хангая гээд 2011 оноос хойш аваад үзэхээр нийтдээ 5 ийм нэгжийг дамжиж явсан байдаг юм байна. Ерөнхийлөгчийн дэргэд байсан байна. Ерөнхийлөгчийн

Тамгын газрын дэргэд байгуулж байж, Ерөнхий сайдын дэргэд байгуулж байсан байна. Засгийн газрын хажууд байж, БОАЖЯ-ны дэргэд Орчны бохирдлыг бууруулах хороо гээд тусдаа ийм нэгж байгуулж байж. Гэхдээ энэ тогтвортой ажиллаж байгаагүй 1-2 жил ажиллаж байгаад л энэ харьяалал нь солигдож байсан дүр зурагтай юм байна.

Тийм учраас энэ бүтцийг тодорхой болгоод, салбар хоорондын уялдаа холбоог хангаж үр дүнтэй ажиллуулъя гэдэг ийм 4 дэх саналыг өгсөн.

Тав дахь санал. Энэ санхүүгийн эх үүсвэрийг нь тооцоолж, хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлэх ёстой юм байна. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хийсэн дүн шинжилгээгээр одоо бид нарт тавьчихсан тэр 2017 оны Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 80 хувийн санхүүжилтийн эх үүсвэр өөрөө тодорхойгүй байна гэдэг дүгнэлт өгсөн.

Тийм болохоор энэ урт, дунд, богино хугацааны бодлогыг хэрэгжүүлэхдээ санхүүжилтийн эх үүсвэрийг нь бас тодорхой давхар тооцож явах ёстой юм байна гэж байгаа юм.

Зургаа дахь санал нь агаар, хөрс, ус, орчны бохирдлыг бууруулахад төр, хувийн хэвилийн байгууллагын түншлэлийг хөгжүүлэх, инновац, технологи, хувийн дэвшлийг ашиглах, хувийн хэвшлийг татварын зээлийн бодлогоор дэмжих гэдэг ийм санал өгч байгаа юм.

Долоод нь энэ чиглэлийн энэ орчны бохирдлын таналт, хяналт, шинжилгээний сорьцын мэдээллийн сан бүрдүүлж, харилцан мэдээлэл солилцох горимыг тогтоох санал өгч байна.

Найд нь дотоод орчны чанарт тавигдах ийм суурь үзүүлэлт бүхий шаардлага, стандартыг шинэчлэн

батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг лабораторийн дүгнэлтийг бас нийтэд ил тод байршуулж байя гэдэг санал байна.

Есдүгээрт нь хог хаягдлын менежментийг сайжруулах. Энэ хураамжийн хэмжээг нь шинэчлэх, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах, аюултай хог хаягдлыг устгах, дахин боловсруулах стандартын шаардлага хангасан төвлөрсөн байгууламжийг байгуулах гэдэг санал.

Аравд нь ариун цэврийн байгууламжийг шинэчлэх, стандартад нийцсэн эко ариун цэврийн байгууламжаар солих арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх, ариутгал, халдваргүйжил хийх гэдэг санал.

Арван нэгд нь усны бохирдолтой газрыг нөхөн сэргээх, ногоон бүс байгуулах, ургамал мод тарих зэрэг арга технологийг хэрэглээнд нэвтрүүлэх ийм санал.

Арван хоёрт нь усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг шинэчлэх, усны бохирдлыг бууруулах, хаягдал усыг дахин ашиглах технологийг нэвтрүүлэх, газрын доорх усны нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг үе шаттайгаар хязгаарлах, усны салбарын чадавхыг бэхжүүлэхэд улсын төсөвт төвлөрсөн хураамжийг зарцуулах.

13-д нь энэ барилга, зам, тээвэр, гудамж талбай, орчны стандартыг мөрдүүлэх, энэ чиглэлийн зөрчлийг шуурхай таслан зогсох урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

14-д нь энэ чиглэлээр ер нь орчны бохирдлын улмаас эрүүл мэндэд үзүүлдэг сөрөг нөлөөг таниулах, урьдчилан сэргийлэх талаарх зөвлөгөө, мэдээллийг олон нийтэд тогтмол хүртээмжтэй хүргэх. энэ чиглэлээр ялангуяа Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааг сайжруулах гэдэг ийм 14



саналыг танилцуулж байна. Боловсрол үргэлжлээд тавьчих уу?

**Д.Цогтбаатар:** Ингэе хэдүүлээ бас ажлаа. Энэ чинь нэлээн хэлэлцүүлэг явагдах учраас ажлаа хялбарчлах үүднээс энэ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн талаар та сая ярьчихлаа.

Дараагийнх нь юу? Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдлын сэдвийн талаар бас та танилцуулна гэж байгаа шүү дээ. Нэгтгээд энэ Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаарх танилцуулгаа та хамтатгаад хийчих. Энэ хоёрыгоо хамтатгаад асуулт асуугаад явчихъя тэгэх үү? Сүнжид даргын микрофоныг өгье.

**Д.Сүнжид:** Хоёр дахь сэдэв боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал байгаа.

Энэ хүрээнд бид нар БШУЯ-тай хамтраад судалгаа хийлгэсэн. Сургуулийн өмнөх боловсрол, сургуулийн өмнөх боловсрол, мэргэжлийн болон сургалт үйлдвэрлэлийн төв, түүнээс гадна дээд боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал гээд энэ судалгаан дээрээ үндэслээд энэхүү сэдвийг боловсруулсан. Нийтдээ Монгол Улс 1229597 ийм суралцагчтай. 4А-гийн зарчмаа буюу хүрэлцээтэй байх, хүртээмжтэй байх, хүлээн зөвшөөрөгдсөн байх, нийцсэн зохицсон байх гээд энэ 4 үзүүлэлтээр энэхүү 4 салбарыг аваад үзвэл нөхцөл байдал ямар байгаа вэ гэдгийг илэрхийлсэн.

Тэгэхээр Сургуулийн өмнөх боловсролын байгууллага дээр хүртээмжийн асуудал юун түрүүн нэгдүгээрт гарч ирдэг. Хоёрдугаарт нь өөрийн сургалтын байгууллагын орчинтой холбоотойгоор ийм аюултай, хадгалж болохгүй аюултай тоглоом, батарей, хүүхдэд эрсдэлтэй байж болзошгүй тийм зүйлүүдийг давхар

принтер гэдэг юм уу ийм галын аюулгүй байдлыг хангаагүй энэ тоног төхөөрөмжийг бас зэрэгцэн энэ байрлачихвал тийм байна гэдэг асуудлыг энэ сургуулийн өмнөх боловсрол дээр ярьсан.

Хоёрдугаарт нь цэцэрлэгийн хүүхдийн хоолны чанарын асуудлыг хөндсөн. Энэ дээр ялангуяа 7 мянган хүүхэд шим тэжээлээ бүрэн авч чадахгүй байгаа юм байна. Тийм учраас энэ тал дээр нь анхаарал тавих ёстой гээд.

Багш ажилтны хүрэлцээ хангалтгүй. 2-4 мэргэжлийн багш ажилтан байнга дутагдалтай.

Ялангуяа орон нутагт, аймгуудын хэмжээнд. Энэ дутагдалтай явдаг юм байна. Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогын тухайд бодлого байгаа боловч түүнийгээ мэддэг, хэрэгжүүлдэг бүтэц мөн санхүүжилтийн асуудалд дутагдалтай байна гэдгийг нь дүгнэсэн. Тийм учраас Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүрээнд энэ асуудал дээр нэгдүгээрт нь ялангуяа орон нутаг тэр 1970 онд баригдсан энэ шаардлагаа хангахгүй байгаа энэ барилгуудыг үе шаттайгаар шинэчлэх асуудал, гадна орчны тохижилтыг хангах асуудал, Улаанбаатар хотын цэцэрлэгүүдэд тулгамдаж тавьдаг юм байна.

Дотоод орчны энэ агаарын чанарын асуудал бол бүх цэцэрлэг, хот хөдөөгүй ийм шаардлагатай асуудал байдаг юм байна. Багш нарын хүний нөөцөөр хангах асуудал, давтан сургах асуудал их чухал юм байна лээ. Энэ Сургуулийн өмнөх боловсрол дээр багш нарын хэлж байгаа хариултаас үзэхээр бид нар хувь хүний хөгжил, боловсролын салбар дахь шинэчлэл хууль, эрх зүй гэдгээр хичээл, сургалтыг тогтмол авч чаддаг, дахин сургалтад хамрагддаг. Харин хүний эрх ялгаварлан гадуурхалтаас ангид байх гэдэг юм уу энэ талаар бид нар төдийлөн сургалтад хамрагдаж чаддаггүй гэдгээ хэлсэн

байсан. Тийм учраас энэ дээр нь анхаарал хандуулах ёстой гэж үзсэн.

СӨБ-ын салбар дээр ахиад нэг хэлэх ёстой асуудал бол тэгш хамруулан сургах асуудал байгаа. Энэ дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургах асуудал ер нь бүх шатны салбар боловсролын салбарт маш бага хувийг эзэлж авдаг. Тийм учраас энэ 2023 оны боловсролын салбарын багц хуулийн шинэчлэлээр заасанчлан, үүнийг хэрэгжүүлэх бол бодитой ажил хэрэг болгох шаардлага байна гэж дүгнэсэн.

Ерөнхий боловсролын салбар дахь хүний эрхийн зарим асуудал дээр энэ дээр сургуулийн анги дүүргэлт, орчныг бид нар та бүх л дээд мэргэжлийнх, сургуулийн өмнөх, ерөнхий бүгдэд нь л ярьж байгаа юм. Сургуулийн өмнөх боловсрол дээр гарч ирж байгаа зүйл 50 хүртэлх анги нэг дүүргэлт байдаг гээд. Яг нийтэд нь аваад үзвэл ерөнхий стандарт гарч байгаа боловч Улаанбаатар хотын хэмжээнд зарим аймгийн хэмжээнд 50 хүртэлх анги дүүргэлттэй байгаа нь зай талбайн стандарт, багцын хүрэлцээ, хүүхдүүдийн сурах орчин, тав тух, хөтөлбөрөө үнэхээр ойлгож таньж мэддэг, чаддаг эсэхэд нөлөө үзүүлж байна гэж дүгнэсэн.

Сургалтын нөөц хэрэглэгдэхүүний тухайд лаборатори тэр хичээлийн дадлагын хичээлд хэрэглэхдээ шаардлагатай байдаг, хэрэгтэй байна гэж үзсэн. Энийг тэгэхдээ 2023 онд санхүүжилтийг нь эрс сайжруулсан байна лээ. Тийм учраас энэ цаашидаа шийдэгдээд явах найдвар байгаа. Тэгэхдээ анхаарах нь зүйтэй гэдгийг нь оруулсан байгаа.

Сурах бичгийн агуулгад хүний эрхийг тусгаж байгаа байдал харилцан адилгүй байна. Ер нь их жендерийн, хүний эрхийн мэдрэмжгүй жишээ, зураг дүрслэл их авдаг юм байна.

Тийм учраас тэр сургалтын хөтөлбөр боловсруулах, сурах бичгийг

шинээр зохиохдоо, түүнийг нь хүлээж авахдаа энэ шалгуурыг бас нэгэнт хуульдаа жендер болон хүний эрх боол заавал үзэх ёстой агуулга гэж Боловсролын тухай хууль дээр шинээр заасан учраас түүндээ нийцүүлэх ёстой гэдгийг дүгнэсэн.

Тэгш хамруулан сургах бол өмнө хэлсэнчлэн бүх л сургалтын байгууллагуудын шийдэх ёстой асуудал, хуулийн хүрээнд заачихсан зорилгыг хэрэгжүүлэх ёстой. Ялангуяа нөөцөөр хангах асуудал байна л даа. Багш, тэр тоног төхөөрөмж, тусгай хэрэглэгдэхүүн, хичээлийн ном, сурах бичиг гээд бусад асуудлаар хангах тухай асуудал байна. Ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэл, үе тэнгийн дээрлэхэлтийн асуудал нь ерөнхий боловсрол дээр тэмцэхгүй болохгүй. Сургуулийн орчинд үнэхээр их байгаа асуудал юм байна. 10 хүүхэд тутмын 3 нь ямар байдлаар бид нар ийм асуудалд өртдөг, цахим хэлбэрээр өртдөг, багшаасаа өртдөг, үе тэнгийнхнээсээ өртдөг гэдэг хариулж байгаа юм. Түүний эсрэг ямар арга хэмжээ авсан бэ, үр дүнд хүрсэн үү гэхээр тийм гэж хэлж байгаа хариулт ер нь байхгүй.

Тэгэхээр энэ дээр тодорхой. Бид нар арга хэмжээ авахгүй бол энэ үнэхээр ерөнхий боловсролын сургуулиудын хэмжээн тодор бүүр асуудал болчихсон хүний эрхийн ийм зөрчил юм байна.

Хувийн өмчийн боловсролын сургалтын байгууллага дээр хяналт тавих хэрэгтэй байна гэж дүгнэсэн, хуульд орсон. Тэгэхдээ хяналтыг төрийн байгууллагаас тодорхой хэрэгжүүлж байх хэрэгтэй байна гэдгийг дүгнэсэн.

Нэг орхигдсон асуудал өдөр өнжүүлэх төвийн үйлчилгээ юм билээ. Өмнө нь 2002 оны Боловсролын тухай хууль байх үед бол түүнийг дагаад энэ 20 оны аргачлал байсан байна. Өдөр дамжуулах төвд тавих шалгуур үзүүлэлт гээд. Одоо тэр нь хүчингүй болчихсон, хуульд заагаагүй.

Тэгэхээр хэн хариуцах нь тодорхойгүй, ямар стандарт хангах нь тодорхойгүй нэг ийм үйлчилгээ зэрэгцээд байж байгаа. Үүнийг хуульчлах шаардлагатай гэдгийг дүгнэсэн.

Мэргэжлийн боловсролын тухайд бага хүүхэд энд элсдэг. Энэ дээр ямар асуудал гарч байна гэхээр элсэлт ба төгсөгчдийн тэр зах зээлийн мэргэжлийнх нь яг зах зээлд хэрэгтэй мэргэжлийг бид нар эзэмшүүлж чадаж байгаа юу гэдэгтэй дүгнэлт хийх хэрэгтэй юм байна. Тэгээд лабораторид тоног төхөөрөмж, дадлага ажил их хийдэг учраас тэр нөөцийг хангахад анхаарах ёстой юм байна.

Тэтгэмжийн асуудлыг хуурамчаар бүрдүүлээд тухайн үед сар сард нь өгөөд байхаар аваад байна гэж үзсэн учраас нэгмөсөн өгье гэдэг байдлаар зохицуулчихсан явж байгаа. Тэр нь хэр оновчтой вэ гэдгээ эргэж бас дүгнэх шаардлага байна гэж үзсэн.

Төгсөгчдийн хөдөлмөр эрхэлж байгаа байдлыг үзэхээр бага юм билээ. Тэгэхээр бид нар энэ хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтээ харж байгаад энэ дээр бас цаашид ямар мэргэжлээр сурвал зохистой вэ гэдэг дээр бас дүгнэлт хийх ёстой гэдгийг мэргэжлийн боловсрол дээр дүгнэсэн.

Дээд боловсролын тухайд ямар асуудал байна гэхээр ер нь бол орчин хангамж дээр ганцхан зүйл хэлж байгаа юм. Өмнөх 3 дээр сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол дандаа нэг яригдаад байсан асуудал байр, орчин, стандарт, сургалтын хэрэглэгдэхүүн дутмаг байна л гээд байсан. Бүгд хүртээмжтэй биш.

Дээд боловсрол дээр тийм юм байхгүй байна. Тэр дээр нэг л хэлж байгаа юм нь интернэт л бид нарт хэрэгтэй л гэдгийг хэлдэг юм байна л даа. Багш, сурагчгүй. Багш, суралцагч аль аль нь. Бусдаар тэр сургалтын нөөц

хэрэглэгдэхүүн бол тэр дээр асуудал алга гэж үзэж байгаа юм байна. Өөрсдөө олоод хийчхэж болдог гээд.

Харин дээд боловсрол дээр 2 асуудал ярьж байгаа. Боловсролын зээлийн сангаас тэтгэмж олгодог, тэтгэлэг олгодог. Энэхүү тэтгэлгийг олгохдоо яг хэрэгцээтэй хүүхдүүдэд нь олгох тухай асуудал, тэтгэлгээс гадна бас магадгүй энэ хагас өнчин, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй энэ хүүхдүүдийг суралцахад нь зориулаад амьдрах зардал бас олгох тухай асуудлыг зохицуулах хэрэгтэй байна гэдэг ийм дүн шинжилгээ хийж байгаа.

Нэмэх нь суралцагчдад дарамт, хүчирхийлэл үзүүлэхгүй байх, тэрийг дотоод журамдаа их, дээд сургуулиуд зохицуулах шаардлагатай юм байна. Хөдөлмөрийн тухай хуулиар бид нар ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа гээд ингээд тэрийг тодорхойлчихдог. Яг энэ суралцагчдад багшаас, ажилтнаас гэдэг юм уу энэ зохицуулагдаагүй байна гэж үзсэн учраас энийг зохицуулах шаардлагатай байна гэдэг ийм дүгнэлтийг дээд боловсролын тухайд хийсэн. Ингээд 11 саналыг танилцуулж байгаа.

Нэгдүгээрт нь бүх шатын боловсролын сургалтын байгууллагын орчин, дутуу байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдлын стандартыг хангуулах, боловсролын байгууллагын барилга өргөтгөлийн ажилд хөндлөнгийн хяналт. Ялангуяа эцэг эх юм уу асран хамгаалагч юм уу гуравдагч этгээдийн хяналтын төлөөллийг оролцуулаад ийм хяналт тавих боломжийг бүрдүүлэх тухай эхний санал.

Хоёр дахь санал нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчийг дэмжих төв ажиллуулах, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, багшийн туслахаар ажиллуулах, сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох, тохирох орчныг бүрдүүлэх, хичээлийн цагийг уян хатан зохицуулах,

багш, багшийн туслах ажилтан нэмэгдэл хөлс олгох зэрэг хуулиар тогтоогдсон арга хэрэгслийг үр дүнтэй хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах гээд ийм хоёрдугаар санал байгаа. Тэгш хамруулан сургахтай холбоотой.

Гуравт нь сургууль завсардсан юм уу, сургуульд огт суралцаж байгаагүй хүүхдүүдийн бүртгэлийн нэгдсэн сан үүсгэх хэрэгтэй юм байна лээ. Одоо бол мэдээллийн сан нь их харилцан адилгүй, зөрүүтэй мэдээллүүд ирээд байдаг юм байна. Тийм учраас үүний нэгдсэн сан үүсгээд, тэгээд боловсролд хамруулах арга хэмжээг авна гээд.

Дөрөвт нь мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцуулах мэргэжлийн чиглэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй нийцүүлж өөрчилж, тэдэнд олгох тэтгэлэг олгох ийм журмыг өөрчилж гэдэг ийм саналыг дэвшүүлсэн.

Зургаад нь хувийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, шалгуурыг нарийвчлан журамлах, хэрэгжилтэд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хяналт тавих гэдэг санал.

Долоод нь хүүхдийн өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхэлж тавигдах шаардлага, стандарт, хууль, эрх зүйн орчныг бий болгох.

Наймд нь малчин эрхийн хүүхдүүд бага боловсролыг гэртээ ойр эзэмших, суралцагч цахим зайны зэрэг бусад хувилбарт боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна гээд хуульд заачихсан хувилбарт боловсролыг эзэмших бодит нөхцөл байдлыг бүрдүүлэх ийм саналыг өгсөн.

Есөд нь сургуулийн орчинд ялгаварлан гадуурхалт үе тэнгийн дээрлэхэлтээс урьдчилан сэргийлэх

ажлыг эрчимжүүлэх, бодитой үр дүн гаргах санал.

Аравт нь их, дээд сургуульд суралцагчдад багш ажилтнаас аливаа зохисгүй дарамт хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэхийг хориглох, гомдол гаргах талаар сургуулийн дотоод журамд зохицуулах. Энэ талаар сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулах санал байгаа.

Хамгийн сүүлийн санал нь Боловсролын ерөнхий хуульд заачихсан энэ төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, хэмжээг батлах аргачлалыг Боловсрол, шинжлэх ухааны сайдаас батлах ёстой. Энэ дээр эцэг эхээс гаргах ёстой зардлыг интервалаар тооцож, тэрхүү аргачлалыг батлах, үүнд нь хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах гэдэг ийм саналыг уламжилж байна. Танилцуулж дууслаа.

**Д.Цогтбаатар:** Хэлэлцэж байгаа асуудалтай танилцуулсан асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд 2 асуудлаар Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаарх танилцуулга, Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаарх танилцуулга. Энэ хоёрын талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр Монгол Улсад яг Хүний эрхийн нөхцөл байдлын 23 оны тайлан илтгэлтэй холбогдуулан бас тодорхой шинэлэг гэдэг юм уу, урьд өмнө хүний эрхийн нөхцөл байдалд бас дурдагдаж байгаагүй асуудлууд оронд талархалтай байна.

Тухайлбал, энэ эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбогдуулан энэ дотоод орчны агаарын бохирдлын сэдвийг бол бас анх удаа хөндсөн байна. Энэ бол яг ялангуяа манай ерөнхий боловсролын сургуулиуд, эмнэлэг,

сургуулийн өмнөх,цэцэрлэг гээд олон газруудад их чухлаар тавигдаж байгаа. Ер нь 2023 оны 11 сард байх нийслэлийн 18 дугаар сургуулийн 20 гаруй хүүхэд ангидаа хордоод, тэгээд Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн дүгнэлт гарахад бол яг дотоод орчны агаарын бохирдол гэхээс илүүтэй зүгээр агаарын агаар дахь нүүрстөрөгчийн юу ихэдсэн ч гэдэг юм уу яг тийм мэргэжлийн нарийн дүгнэлт гараагүй.

Тэгэхээр яг энэ дотоод орчны агаарын бохирдлын асуудлаар манай Хүний эрхийн Комисс болон мэргэжлийн байгууллагуудтай хамтраад ажиллах шаардлага байгаа юм. Ер нь бид нар сайн мэдэж байгаа. Энэ жил бүрийн сургууль цэцэрлэгийн засварууд зундаа хичээл амарсан хойно явагдаад. Яг 9 сарын 1-нд хичээл ороход нэл будаг үнэртсэн, будаг шохой үнэртсэн энэ ангид ордог. Энэ бол үнэхээр яг тэр агаарын чанарын хувьд асар тийм сөрөг нөлөөтэй ийм байгаа юм.

Гэвч яг энэ дотоод орчны агаарын бохирдол дээр яг Монгол улсад энэ чиглэлийн мэргэжлийн нарийн дүгнэлт гарах тийм лаборатори байгууллагууд бай байна уу, үгүй юү? Тухайлан манай Хүний эрхийн Комисс энэ чиглэлээр судалгаа хийхэд яг энэ мэргэжлийн дүгнэлт хийх, агаарын чанар дахь химийн янз бүрийн нэгдлүүдийг тодорхойлоход ийм бас дүгнэлт, бэрхшээл ер нь гарч байсан уу? Энэ тал дээр яг холбогдох байгууллагууд тэр дотор Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн газар зэрэгт холбогдох ямар санал зөвлөмжүүд өгч байгаа вэ? Агаарын бохирдол гэхээр бид нар ерөнхийдөө нүүрс, утаа гээд гадаад орчны яриад ирдэг боловчиг. Хүн бол амьдралынхаа бараг 80-90 хувь нь дотоод орчиндоо байдаг. Тэр дотроо ялангуяа өсвөр насны хүүхдүүд, эмнэлэгт хэвтэж байгаа өвчтөнүүд эрүүл мэндийн эмнэлгийн тэр барилга, будаг, тэгээд янз бүрийн жишээлбэл, дорож ч гэдэг юм уу тодорхой эрүүл мэндэд хор хөнөөлтэй бодис ялгаруулах ийм нөхцөл, эрсдэл

байгаа. Энэ чиглэлээр тэгэхээр ямар зөвлөмжүүд гарах вэ гэдгийг асуумаар байна.

Хоёрдугаарт нь энэ боловсролын асуудал дээр бол бас чухал чухал дүгнэлтүүд байна. Ялангуяа тэр ЕБС-ийн сурах бичиг дэх хүний эрхийн асуудал. Үндэсний үнэт зүйлээс гадна дэлхий нийтийн хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн болон үнэт зүйлүүдийг хүлээн зөвшөөрсөн, агуулгын хувьд жендерийн болон бусад ялгаварлан гадуурхалтгүй байх нь үнэхээр чухал.

Гэтэл манай боловсролын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, эрдэмтэд болон олон дүгнэлтүүд дээр энэ сурах бичиг бол ерөөсөө жендерийн тэгш бус байдалтай гэдэг нь гарч байна. Тухайлбал, энэ судалгаан дээр бас харагдаж л байна л даа. Ерөнхийдөө эрүүл мэндийн жишээлбэл сурах бичгийн жендерийн агуулга 80 буюу 20 хувьтай тэр дотроо эмэгтэйчүүдийг дүрслэн харуулж байгаа дүр зураг нь бол дандаа ийм сөрөг шинжтэй гэдэг юм уу, ялгаварласан, хортой байдлаар ер нь тусгасан байна.

Тэгэхээр мөн яг энэ сурах бичгийн агуулгатай холбогдуулан БШУЯ руу ямар зөвлөмж өгч байгаа вэ? Яг одоо энэ цаг мөчид БШУЯ дээр хөтөлбөрүүд болон сурах бичгийн агуулгын шинэчлэлийн ажлууд явагдаж байгаа. Энийг бид нар хийхгүйгээр хүний эрхийн мэдрэмжтэй эргэн төлөвшүүлэх ийм боломж Монгол Улсад гарахгүй. Сурах бичиг нь агуулгын алдаатай.

Энэ дээр жишээлбэл, энэ хүүхдэд тодорхой итгэл үнэмшлийг тулган хүлээлгэсэн гэдэг юм уу, иргэний боловсрол, шашны боловсрол зэрэг асуудлууд нь их учир дутагдалтай байна гэж. Жишээлбэл, тэр эшлэн авсан зохиолуудын ихэнх нь Буддын шашны философийн номууд байна. Идэвхгүй дүрээр хүмүүсийг харуулсан гэх мэтийн ийм агуулгын алдаа байна. Тэгэхээр энэ дээр ямар зөвлөмж, чиглэлүүд өгөх вэ?

**Д.Цогтбаатар:** 2 дугаар  
микрофон өгье.

**Д.Сүнжид:** Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Дотоод орчны агаарын чанарын стандарт гэж байгууллагын хэмжээнд баталсан стандарт байдаг юм байна. Тийм учраас үндэсний хэмжээнд стандарт батлах хэрэгтэй гэдэг зөвлөмжийг өгч байгаа юм. Энэ дээр нэг лаборатори байна дотоод орчны агаарын чанарын стандартад хэмжилт хийдэг. Тэр лаборатори нь болохоор магадлан итгэмжлэгдсэн ганцхан лаборатори учраас бүх дотоод орчны агаарын чанарт бид нар бүтэн хэмжээгээр энэ үзүүлэлтийг нь гаргаж чаддаггүй гэж байгаа юм.

Тийм учраас лабораториудыг олируулах ёстой юм байна. Хоёрт хийх ёстой ажил юу гэхээр энэ дүгнэлтийг нь ил болгооч гэдэг саналыг комисс өгч байгаа юм. Тэр сургууль, цэцэрлэг, эмнэлэг гээд хүн олон орж гардаг, хүн олон бөөгнөрдөг тэр газруудын ялангуяа агаарын чанарын стандартыг бусад хүмүүс харах боломжтой байдлаар нээлттэй байршуулбал бас түүнд тавих нэг хяналт нь нэмэгдэнэ гэж үзэж байгаа юм.

Нэгдүгээрт, стандартаа яг албан ёсны болгож үндэсний болгож батлах.

Хоёрт нь лабораторийг нэмж магадлан итгэмжлэх.

Гуравт нь лабораториудын дүгнэлтийг ил тод болгох.

Дөрөвд нь хийх ажил нь энэ яг энэ эрүүл мэнд, боловсролын салбарт өөрсдөөсөө хамаарах дотоод орчны агаарын чанарыг сайжруулах ажлыг хийгээч гэдэг зөвлөмжийг энэ Комиссын илтгэлийн мөрөөр хүргүүлнэ. Тэр нь яг таны хэлдэг ядаж 9 сар тэр сургуульд орохоо дөхүүлэхгүйгээр засвараа хийдэг байх, тэр агаар сэлгэлт гээд өөрсдөөс

хамаарч хийж болох механик өдөр тутмын үйлдлүүд байдаг юм байна лээ. Тэр дээр нь бас анхаараач гэдэг зөвлөмжийг хүргүүлнэ. Хамгийн сүүлд нь хийх ёстой ажил эцэг эх, асран хамгаалагч нар, багш нар, энд ажилладаг хүмүүс бас энэ талаар их ойлголттой байх ёстой юм байна.

Яагаад гэвэл яг таны хэлж байгаа тэр тоо баримт харахаар бид нар 0-5 насны хүүхдүүдийн нас барж байгаа шалтгааны энэ нэг том шалтгаан нь энэ байна. Дотоод орчны агаарын чанарын муугаас болоод, хангаагүйгээс болоод ингээд энэ уушиги нь бүрэн бүрэлдээгүй хүүхдүүд чинь нас барах, эрүүл мэндийн хувьд асуудалтай, өвдөх шууд ийм эрсдэл болдог уу гэдгийг л эмч нар, Нийгмийн эрүүл мэндийн төв судлаад хэлчихсэн. Тийм болохоор энийг бас бид нар таниулах хэрэгтэй байна гээд ийм 4, 5 ажлыг төлөвлөөд байна.

Хоёр дахь асуултын тухайд хүний эрхийн ЕБС-ийн бид нар иргэний ёс зүйн боловсрол гээд сурах бичигт Комиссоос захиалга өгөөд, дүн шинжилгээ хийлгэж үзсэн. Тэр дээр бас л яг адилхан дүн, дүгнэлт гарч байгаа юм л даа. Бусад байгууллагатай яг л адилхан.

Ер нь бид нар хүний эрхийн талаар, энэ юмыг танин мэдэх, ертөнцийг философийн тэр үзэл баримтлалын талаар өөрсдөө эргэцүүлэн бодох тийм боломжийг өгөхгүйгээр нэгдүгээрт шууд тулгадаг юм байна догматик.

Хоёрдугаарт, авч байгаа жишээ баримт маань заримдаа хэт хуучинсаг, ойлгомжгүй байна.

Гуравдугаарт, домгийн шинжтэй ч гэдэг юм уу тэгж байснаа гэнэт орчин үеийн мэдлэг мэдээлэл болоод явчихдаг. Ийм харилцан адилгүй янз бүр байна. Хүний эрхийн талаар энэ шалгуурт нийцэхгүй байна. Энэ дээр зураг хөрөг, жишээ бүгдийг нь л авсан байна л даа. Бүгдэд нь дүн шинжилгээ хийсэн байна

лээ. Тэгэхээр одоо энэ бид нар иргэний ёс зүйн боловсролын сурах бичигт, хүний эрх, жендерийн шалгуур хийсэн дүгнэлтийг БШУЯ-тай хамт нэгдүгээрт хэлэлцүүлэг хийсэн, танилцуулсан. Хүлээн зөвшөөрч байна лээ. Тэгээд сайжруулна гэж байна.

Хоёрт нь бид нар бичгээр, энэ зөвлөмжөөр хүргүүлсэн. Одоо энэний мөрөөр БШУЯ-наас энэ шинэчлэх гэж байгаа сургалтын хөтөлбөр дээрээ санал өгөөч гээд ирүүлчихсэн байгаа. Ингээд эргэх холбоотой л хамтарч ажиллаж байгаа юм. Одоо яаж цаашаа нь хөтөлбөр нь, удирдамж нь, сурах бичиг нь, агуулга дээр хүний эрхийн талаас нь бид нар бас саналаа өгөх байдлаар, зөвлөх байдлаар ингэж хамтарч ажиллаж гээд явж байгаа.

**Д.Цогтбаатар:** Мөнхцэцэг гишүүнд нэмэлт асуулт асуух боломж өгье, микрофон өгье.

**Ц.Мөнхцэцэг:** Тэр дотоод орчны агаарын бохирдол дээр Эрүүл мэндийн яам, Боловсролын яам руу зөвлөмж өгөхөөс гадна яг тухайн барилга барь гэж байгаа. Жишээлбэл, ерөнхий боловсролын, цэцэрлэгийн барилга байна уу, эмнэлгийн барилга байна уу энэ барилгыг барих гол бүтээгдэхүүн будаг, шохой гэдэг юм уу эдгээрийг гаалиар оруулж ирэхэд нь хүний эрүүл мэндэд эсэх талаар тийм стандарт тавих энэ чиглэлээр илүү анхаармаар байгаа юм. Нэгэнт хорттой будаг гэдэг юм уу, эсвэл тухайн нөгөө сургуульд тавигдаж байгаа тэр агааржуулалтын систем энэ тэр нь хүнд нийцэхгүй бол энэ чинь угаасаа болохгүй.

Тийм учраас Барилгын яам руу, мөн гаалийн газар руу бас тодорхой стандартыг хүргүүлэхэд эсвэл энэ чиглэлээр байхгүй бол илүү өндөр түвшинд ажилламаар санагдаад байдаг. Тендер зарлах процесс ч гэсэн ялангуяа тэр тухайн тендерт шалгарч байгаа барилгын компанийн барилгын бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд

нийцсэн байх гэдэг энэ шаардлага ер нь байдаг юм уу, үгүй юу?

**Д.Цогтбаатар:** 2 дугаар микрофон өгье.

**Д.Сүнжид:** Мөнхцэцэг гишүүний энэ саналыг бид нар 3 сарын 6-нд хэлэлцүүлэг хийсэн Эрүүл, аюулгүй орчны амьдрах эрхийн хүрээнд. Тэр дээр бас яг ярьсан санал барилгын барилгын материалд нь хэрхэн хяналт тавих вэ гээд. Яг энэ илтгэлд яг энэ барилгын стандарттай холбоотой дэлгэрэнгүй ороогүй. Тэгэхдээ бид нар үүний мөрөөр нь авах арга хэмжээнд нь бас энэ гааль, барилгыг хэрхэн тусгах вэ гэдгийг бас хоорондоо зөвлөлдөж байгаад арга хэмжээ авна.

**Д.Цогтбаатар:** Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

**Ж.Сүхбаатар:** Өнөөдөр энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын 23 дахь илтгэлийн хүрээнд энэ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх боловсролын талаарх асуудлууд гээд энэ. Яг одоо иргэдийн хувьд маш их гомдол, санал, бухимдал, шүүмжлэл тэр байтугай олон нийтийн эсэргүүцэл үүсэж байгаа асуудлуудын талаар бол Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл орж ирж байна л даа.

Жишээлбэл, утаа униар, агаарын бохирдлын асуудал байж байна. Үүнийг бол сүүлийн олон жил бас ярьж, зарим талаар дэвшил гараад, зарим талаар бас асуудлууд үүсээд ингээд яваад байгаа. Энэ дээр би яривал их олон юм хөндөгдөхөөр л өргөн хүрээтэй асуудал байж байна л даа. Сонгуулийн жил таарчихлаа. Тэгэхдээ миний илүү акцент өгөх гэж байгаа юм нь хөрсний бохирдол байгаа юм. Сая энэ Чингэлтэй дүүрэгт та хэдийн илтгэлд энэ дурдагдсан манай Чингэлтэй дүүрэг хүртэл Дэнжийн мянга гээд тэгдэг юм уу энэ дээр жишээлбэл хөрсний бохирдол өндөр хэмжээтэй байна гэдэг юм уу, нэлээн хэдэн дүүргүүдийг дурдсан байна л даа.

Тэгэхээр энэ асуудлууд ингээд байгаад байгаа юм. Угаасаа хөрсний бохирдлын асуудал, нүхэн жорлон гээд л. Нэг худаг тойроод энд 30, 40 жорлон байдаг гээд л судалгаа байж байна гээд л жишээлбэл ингээд дурдчихсан байна шүү дээ. Тэгэхээр бид нар манай Чингэлтэй дүүрэг дээр бид нар ажил хийсэн юм. Ингээд энэ улсуудыг нь урьж уулзаад, энэ дурдагдаж байгаа асуудал дээр ихэнх аймгууд дээр, бас аймгийн төвүүд дээр бол ер нь удахгүй ингээд асуудлууд үүсээд эхнээсээ эхэлчихсэн явж байна.

Улаанбаатар хотын тухайд ноцтой асуудал нь бид нарт яг байгалийн тэр органик тийм хөрсгүй болчихсон, техникийн хөрстэй болчихсон гэж ярьдаг. Ингээд олон газар ингээд бохирдчихсон. Тэгэхээр ийм байдалд ороод байгаа үүний хамгийн ноцтойг мэргэжилтнүүд хэлж байгаа юм нь бол агаарын бохирдол хэцүү л дээ тодорхой хугацаанд. Заримдаа салхи гараад яачихвал ингээд цэвэршчихдэг. Гэтэл хөрсний бохирдол ямар ч тийм цэвэрлэгээ, цаг хугацаа өнгөрөх тусам цэвэрлэгээ хийдэггүй зузаараад, нэмэгдээд байдаг. Улам гүн бохирдоод байдаг гэж.

Тэгэхээр энэ дээр та хэд маань ингээд ийм бодлогын хөтөлбөр ийм ийм тусгагдсан байна гэхээд яг тодорхой бас ийм бодлого гаргаж ингээж хэрэгжүүлэх шаардлагатай байна гэсэн дүгнэлт хийсэн юм шиг байна. Энэ 2019 онд хөрс хамгаалах газрын доройтлын бууруулах үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн байна гэхчхэн байгаа юм. Яг хэрэгжүүлж чадсан уу, үгүй юү? Энэ 19 оны хөтөлбөрийг би мэдэхгүй байна. Бид нар энд тэнд ингээд л хэсэг бусад яриад байна.

Их Хуралд та хэд маань хандаж байгаа шүү дээ. Яг энд дурдагдсан тэр эрүүл, аюулгүй амьдрах орчны эрхийн талаар сая 600 мянган хүнтэй Улаанбаатар хотын асуудал бол онцгой анхаарал татаж байгаа. Улаанбаатар хот өөрөө их анхаарах шаардлагатай

асуудлууд байна. Тэгэхээр Их Хурлын тухайд ингээд ярихад та хэд юу гэж үзэж байна? Энэ агаар, орчны бохирдол, хөрс хамгаалах асуудал дээр Улсын Их Хурал Засгийн газарт үүрэг, даалгавар өгөх замаар л зөвхөн явахаар байна уу? Зөвхөн хяналт шалгалт хийхээр байх юм уу? Их Хуралд эсвэл дахиад шинэ тодорхой бодлогын гэдэг юм уу, удирдамжаар хангаж тодорхой хууль, тогтоолд өөрчлөлт оруулах шаардлага байгаа юм уу? Аль талд нь байгаа юм? Гүйцэтгэл талдаа байгаа юм уу, бодлогын түвшинд шийдвэрлэх асуудлууд байгаа юм уу ийм асуудлууд байна. Тэгэхгүй бол энэ болгон чинь өөрөө улсын төсөвт сууж байх ёстой байхгүй юу. Өнөөдөр илтгэлийн ингээд ярьж байлаа гэхэд дараа жилийн улсын төсөвт энэ илтгэлийн дагуу ер нь ямар арга хэмжээнүүд Засгийн газрын төсөвтөө суулгаж оруулж ирэв? Ямар арга хэмжээнүүд хийгдэв гэдгийг чинь үнэлж байх ёстой бид нар.

Тэгэхээр энэ асуудал дээр хөрсний бохирдлын чиглэлээр бас яахгүй байна. Энэ хөрсний бохирдлын хүрээнд та хэд бас нүхэн жорлонгийн асуудлууд бас байж байна. Дээр нь хог хаягдлын асуудлууд гээд яг л Улаанбаатар хот дээр олон жил л яригдаад, шийдэл нь заримдаа гарчхаад хэрэгждэггүй, эсвэл зарим нь шийдэл нь тодорхой болдоггүй ийм асуудлуудыг хөндөж тавьсан байгаа учраас энийг бас манай иргэд бас ингээд харж байгаа, энэ илтгэлд ингээд Хүний эрхийн Комисс дүгнэлтүүд хийчихсэн байна шүү дээ. Тэгэхээр яг энэ асуудал дээр би энэ хөрсний бохирдлынх нь чиглэл дээр илүү бас саяын энэ асуудал дээр тодорхой бас мэдээлэл өгөөч гэж хэлэх гэсэн юм.

**Д.Цогтбаатар:** 2 дугаар микрофон.

**Д.Сүнжид:** Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. Хөрсний бохирдол агаарын бохирдлоос илүү хор нөлөөтэй гээд дүн шинжилгээ нь тийм юм билээ. Хамгийн их бохирдчихсон. Ялангуяа



Улаанбаатар хотын хэмжээнд. Бэлчээрийн доройтолтойгоо ярих юм бол үндэсний хэмжээнд бид нар энэ бэлчээрийн доройтол, хөрсний бохирдол, арга хэмжээ авахуйц нэн аюултай түвшинд очсон. Одоо тэгээд юу хийвэл зохистой вэ гэхээр ингээд олон шинжлэх ухааны уулзвар дээр л дүн шинжилгээ хийсэн байна л даа.

Нэгдүгээрт, хог хаягдалтай холбоотой асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэх ёстой юм уу гэж үзсэн. Яагаад гэхээр энэ тариф хураамжаас авхуулаад, хэдийгээр аюултай хог хаягдлыг буулах ийм тусдаа байгууламж бариач гээд хэлчихсэн боловч тэр нь баригдаагүй. Тэр тариф нь бас шинэчлэгддэггүй. Иргэдийн хурал нь шинэчлэх ёстой, он удаан жин шинэчлэгддэггүй. Тэр шинээр баригдах ангилах, ялгах, эргэлтэд оруулах гээд энэ асуудлуудыг нэгдүгээрт хууль тогтоомжийн түвшинд,

Хоёрт нь бодлогын түвшинд илүү шинээр тодорхойлох хэрэгтэй юм байна. Одоо байгаа нөхцөлдөө дүн шинжилгээ хийгээд гэж үзсэн. Үүнийг тэр нөхөн сэргээх арга зам, ногоон байгууламжийг барих, шинэ технологиуд хөрсөө бүсээр нь ангилах, бохирдлоор нь ангилаад тэрнийхээ дагуу аль ангилалд нь ямар хөрс аль район аль хэсэгчилж орсон юм бэ гээд түүнийхээ эсрэг ямар арга хэмжээ авах вэ гэдгийг нь тодорхойлоход анхаарал хандуулахгүй бол ерөнхий яриад явахаар энэ бас тийм ойлгомжгүй байдаг юм болов уу.

Хэрэгжилт дээр нь тийм төдийлөн ахиц гарч байгаа шинэ байдаггүй юм байна. Тэр битгий хэл энэ хөрсний сорьц авдаг байгууллагууд хоорондоо мэдээллээ солилцдоггүй юм билээ. Ус цаг уурын шинжилгээний байгууллагаас хэдэн газраас мэдээллээ авч байгаа. Өөр байгууллагууд авдаг мэдээлэл ямар байгаа юм бэ гээд харилцан солилцоод энэ үндэсний хэмжээний дататай болоод, нэгэнт дата гарчихсан бол бид нар хариу арга

хэмжээгээ зөв оношоо авч чадна. Тэгтэл тийм ч бас үйл ажиллагаа дутмаг юм байна.

Ер нь бид нар энэ хөрсний бохирдлыг тун ч анхаарахгүй байгаа юм байна л гэдэг дүр зурагтай. Яг мэргэжлийн хүмүүс нь санаа зовниж байна. Энэ бол асуудал мөн. Эрүүл мэндэд, амь насанд ингээд үр дагавар учруулаад байгаа. Цаашидаа ч гэсэндээ хэдүүлээ энийг залруулах арга хэмжээ зэрэгцээж авахгүй бол огт болохгүй гэдгийг цөөн хүрээнд ойлгож танин мэдэж хариу арга хэмжээ авч байгаа ийм л шинэжтэй учраас хууль тогтоомжийн хувьд ч гэсэн, бодлогын хувьд ч гэсэн шинээр хэдүүлээ бас энэ ямар арга хэмжээ авах вэ гэдгээ бас шинэчлэх шаардлагатай юм болов уу гэж үзээд дүгнэлтдээ тусгасан. Хэрэгжилт дээр мэдээж шууд анхаарах ёстой. Засгийн газрын түвшинд.

**Д.Цогтбаатар:** Сүхбаатар гишүүнд нэмээд минутын боломж олгоё. Микрофоныг нь өгье.

**Ж.Сүхбаатар:** Энд ингээд хүргүүлж байгаа санал, зөвлөмж гээд энэ юунуудаа ингээд хийж байна. Тэгэхдээ бас Сүнжид дарга Хүний эрхийн комисс бас олон улсын дагуу бас юмнуудыг бас жоохон юугаар ингэж хийж баймаар байгаа юм. Жишээлбэл, ингээд л хийхэд ийм ийм арга хэмжээ, бодлого боловсруулъя, хөтөлбөр боловсруулъя, үр ашигтай зарцуулъя. Гэхдээ та хэд тэрийм 3 юмаар нь бол ингээд явмаар байгаа байхгүй юу. Нэг нь бол тэр полиси /policy/ гэдэг бодлогын асуудал гэдгээр нэг. Нөгөөдөх нь администрейшн /administration/ гээд захиргаа зохион байгуулалт удирдлагын чиглэлээр нь нэг, нөгөөдөх нь тэр спенд /spend/ байна уу бажсет /budget/ нь байна уу санхүүжилтийн тэр зарцуулалт, тэр санхүүжилт, төсвийн схем талаас нь нэг гэж ингэж тийм 3 чиглэлд нь хийж байх ёстой байгаад байгаа.

Яагаад гэвэл энэ Их Хурал дээр танилцуулагдаж байгаа юм. Үүнийг Нийслэлийн иргэдийн хурал дээр тавих асуудлууд байж байна. Засгийн газарт тавих асуудлууд байж байна. Тэгэхээр яг Улсын Их Хурлаар өөрөөр нь заавал хийлгэх юмнууд гээд мэдээж Улсын Их Хуралд илтгэл оруулж байгаа.

**Д.Цогтбаатар:** Сүхбаатар гишүүний микрофоныг нэмээд өгье.

**Ж.Сүхбаатар:** Жишээлбэл, Их Хурал дээр хандаж байгаа гэхэд агаар, ус, хөрс, орчны бохирдлыг бууруулах бодлогыг урт, дунд, богино хугацааны зорилтод нийцүүлэн боловсруулах гээд Их Хуралд шийдвэр га гаргуулна гээд ингэж байна шүү дээ. Тэгэхээр энэ хууль гарга гэсэн санаа юм уу, эсвэл Засгийн газарт үүрэг өгсөн санаа юм уу? Засгийн газар бол Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиар чинь олон янз бүрийн бодлогын юм гаргахаа больчихсон. Засгийн газар өөрөө хэрэгжүүлээд ингээд явдаг. Тэгэхээр энэ болгон дээрээ ингээд жоохон тийм юугаа анхаараарай гэж. Дараа ингээд хийхдээ энэ зөвлөмжүүд эд нараа саяын миний хэлдэг 3 чиглэлд ингэж хуваагаад, Их Хурал дээр яг цэвэр юу шийдүүлэх юм? Саяын 3 талаасаа.

Дээр нь Засгийн газар руу бас өөрсдийнхөө шугамаар хандах юм гэж тусдаа байна. Нийслэлийн иргэдийн хурал, аймгийн иргэдийн хурал тусдаа байж байгаа. Тэгэхээр энийгээ бас яахгүй бол энэ дотор чинь ингээд харахаар ариутгал, халдваргүйжилт тогтмол хийнэ гэж байгаа байхгүй юу. Энийг чинь хийдэг хууль тогтоомж байж л байгаа шүү дээ. Тэгэхээр чинь зэрэг Их Хурлаар ийм шийдвэр гаргуулах шаардлага байна уу, үгүй юү? Тогтмол хийхгүй байгаа чинь тэр гүйцэтгэх байгууллагууд ажлаа хийхгүй байна шүү дээ.

**Д.Цогтбаатар:** Би асуулт асууна. Энэ агаарын бохирдолтой холбогдуулаад утааны сонсгол хийе гэдэг санаачилгыг би Байнгын хороон дээр Энхбаяр сайдыг Байнгын хороон дарга байхад нь гаргаад,

сая Энхбаяр сайд энэ Нүүрсний сонсголыг хийхэд тэр утааны сонсголыг хамтатгаад бид нар хийсэн. Энхбаяр сайдад талархаж байгаа энэ асуудалд бас хариуцлагатай хандаад энэ сонсголдоо бас гишүүний гаргасан саналыг дэмжээд оруулаад явсанд би баяртай байгаа.

Гэхдээ яг тэр хэлэлцүүлгийн үеэр болох, бүтэхгүй их нарийн асуудлууд гарч ирсэн. Агаарын бохирдол буураагүй байхад өөрсдийгөө баахан шагначихсан, шагнал урамшуулал олгочихсон, мөнгө цаас тэр замбараагүй зарцуулчихсан, үр дүн гараагүй байхад ийм юмнууд гарсан. Гэхдээ энэ дээр би юу анзаарсан гэхлээр илүү тэр санхүү тал дээр нь анхаараад явчихна лээ. Таны зүгээс яг энэ утааны гол эх үүсвэр болсон өнөөдөр энэ юу сайжруулсан түлшний үйлдвэр дээр технологийн яг ямар асуудал гарчхаад байна? Алга болчихсон байсан утаа буцаад гараад ирчхэв гэдэг дээр та нар илүү нарийвчилсан судалгаа хийв үү? Энэ дээр би бүүр яг тодорхой юм асуумаар байгаа юм. Тэр санхүүгийн тал дээр тодорхой болчихлоо шүү дээ. Энэ аягүй олон хариуцлагагүй юм байсан байна.

Гэтэл өнөөдөр тэр нүүрс нь Монголоосоо авдаг нүүрс нь Монголоосоо л авч байгаа. Тэр сайжруулсан түлшийг боловсруулдаг үйлдвэр нь байрандаа л байж байгаа тэнд ажиллаж байсан хүмүүс нь ажилладгаараа л ажиллаж байгаа. Тэгээд юу нь болохоо больчихоод тэр алга болчихсон байсан утаа буцаад гараад ирчхээд байгаа юм? Мэдээж технологийн л асуудал гарчхаад байна гэж би ойлгоод байгаа.

Тэгвэл тэр гарчихсан байгаа асуудлыг шийдвэл шийдчих хугацаа болоод тэр алга болчихсон байсан утааг буцаагаад алга болгох тэр технологио сэргээх хангалттай хугацаа байгаад байгаа шүү дээ. Энэ рүү та нар гүнзгий орж харав уу? Энэ дээр би зүгээр Сүнжид дарга та зоригтой хатуу байр суурьтай байна шүү ийм асуудлууд дээр. Та сая хэлж байна л даа. Утаа буурсан

гэхэд хэцүү л байхаар байна гээд. Юун хэцүү утаа ерөөсөө буураагүй, буураад алга болчихсон байсан утаа чинь гарч ирчхээд байна. Тэрийг яг үгээр нь тодорхой дүгнэж хэлж байх ёстой шүү. Энд бид нар бие биедээ ингэж шаардлага тавьж явж байж л ажил сайжирна. Энэ чинь ажлын төлөө тавьж байгаа зүйл.

Хоёр дахь асуулт. Ийм асуулт байна лицензтэй холбогдуулаад. Сая Баянхонгор, Өвөрхангай аймгаар явж яг энэ газар дээрээ энэ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хангагдаж байгаа нөхцөл байдалтай Байнгын хорооны зүгээс газар дээрээ очиж танилц гэдэг чиглэлийг Их Хурлын даргаас өгөөд явж ажиллалаа хөдөө орон нутгаар. Тэр дотроо яг Баянхонгор, Өвөрхангай, Шинэжинст сум дээр очиж ажиллалаа. Энэ дээр юу ажиглагдсан гэхлээр тэндээс нээрээ үнэхээр аягүй олон иргэдийн гомдол байнга гарсаар байгаа. Танай дээр ч ирж байгаа, манай дээр ч ирж байгаа. Тэгэнгүүт энэ дээр би нэг юм асуумаар байгаа юм. Энэ лицензтэй холбогдсон гомдлууд хэчнээн тохиолдолд эрх зүйн тэр гомдол гаргах үндэслэлээ Үндсэн хуулийн энэ эрүүл, аюулгүй орчинд амьдрах бидний эрх зөрчигдөөд байна гэж үндэслэл болгож энийгээ гаргаж ирж байна.

Би яагаад энийг асууж байна гэхлээр ихэнх тохиолдолд энийг очоод ярингуут дандаа Ашигт малтмалын хууль, Газрын тухай хууль, Компанийн тухай хууль энэ асуудлуудынхаа хүрээнд бүх асуудлуудаа шийдчихсэн тийм учраас хуулийн зөрчил байхгүй гээд ингээд иргэдтэйгээ эсэргүүцээд байхад нь хүч түрээд ороод ирж байгаа тохиолдлууд байна. Тэр Шинэжинстэд үнэхээр дэндүү тодорхой байна лээ. Яах аргагүй бид нарыг очиход бүр яг их салхитай ч байж таарсан. Ерөөсөө хоёрхон километрийн зайнд том уурхай барих гээд тэр тоос нь ерөөсөө л 2 км тэр их салхи, шуурганд шууд тэр сум руугаа явах юм байна лээ. Энэ нь ийм ойлгомжтой байгаад байхад яаж яваад

тэр зөвшөөрлүүдээ өгчхөөд байгаа нь сонин байгаад байгаа юм.

Тэгээд өгчихсөн байхад энэ ингээд өгчихсөн, ийм лицензтэй байна, ийм зөвшөөрөлтэй байна гээд амыг нь дарах юм байна лээ. Тэгэнгүүт энэ чинь Үндсэн хуулийн эрхийг зөрчөөд эхэлж байна шүү дээ. Үндсэн эрхийн асуудал гараад ирж байгаа юм. Энэ дээрээ үндэслэж хэр их гомдол гаргаж байна вэ? Яагаад гэвэл энэ хүч мөхөстөөд яг тэр хуулийн техникээрээ бүх юмаа шахаад ирэхэд энэ дээрээ тулгуурлаж байгаад иргэд өөрийнхөө эрхийг хамгаалах цонх байгаа юм байна гэж би харсан. Энийг хэр их ашигладаг юм байна яг амьдрал дээр? Та нарт ирж байгаа гомдлоос үзэхэд.

**Д.Сүнжид:** 2 дугаар микрофон Сүнжид даргын микрофоныг өгье.

Цогтбаатар даргын асуултад хариулъя. Тавантолгой түвшний технологи нь өөрөө нүүрсийг угаагаад ,барьцалдуулаад л буцаагаад л шинэ технологи гэж хэлэхэд их хэцүү юм билээ. Юуг багасгадаг вэ гэхээр азотын исэл тэр үхрийн хүчлийг нь үхрийн ислийг нь л багасгах юм байна. Эхний жилдээ багассан дараа нь яасан бэ гэхээр жижиг уурын зуухнуудаа бид нар хориогүй, түүхий нүүрс төлсөн хэвээрээ л байгаа юм билээ. Жижиг эх үүсвэртэй уурын зуухнууд зэрэгцсэн байна. Ингэж байгаа цагт бид нар нөгөө агаар дахь индекс чанарын үзүүлэлтүүд сайжирна гэж байхгүй л юм байна л даа.

Тийм учраас ер нь цаашидаа Байгаль орчин, агаар орчны бохирдлыг бууруулах Улсын Их Хурлын дэд хороогоор энэ 2023 онд хэлчихсэн байсан. Ер нь тэр коксожсон үйлдвэрлэл, өөр технологийн ямар арга хэмжээ авах юм бид нар түүхий нүүрсний оронд ямар нэгэн тэр түлэх түли хэрэгтэй, тэрийгээ яаж ийм эрүүл мэндэд халгүй болгох вэ гэдэг асуудал руу л технологи оруулж ирнэ гэдэг ийм асуудлыг салбарын шинжээчид, судлаачид нь ярьж байгаа юм байна л даа. Тэгэхээр тэр чад

тэр тал руугаа энэ төр одоо хувийн хэвшил анхаарах ёстой байх гэдэг үүднээс Комисс ийм саналыг оруулсан.

Лицензийн энэ уул уурхайтай холбоотой ирдэг гомдол эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж байна гэж ирдэг нь тун цөөхөн. Усан цахилгаан станцтай холбоотой замын дагуу бид нар оршин суух нөхцөлгүй боллоо, хүн мал гарах гарамгүй боллоо, тоосонд өртлөө гэдгээр ирж байгаа юм. Яг уул уурхай лиценз өгснөөс болоод бид нарын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчлөө гэж гэдэг агуулгаар томъёолдог нь тун цөөхөн юм байна лээ. Тэр нь хуульд нийцсэн үү, үгүй юү гэдэг байдлаар яваад байдаг болохоос биш энэ бид нарын эрхэд хэрхэн нөлөөлж байна вэ гэдэг гомдол 1, 2 л ирдэг. Илүү эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбоотой гомдол Комисст Улаанбаатар хотоос л ирж байгаа. Угаартаж байна бид нар нас барж байна, энэ чинь стандартынх юм уу, хяналтаа тавьж чадаж байгаа юм уу энэ гээд энэ асуудалтай холбоотой ирдэг юм. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Хэлэлцэж байгаа энэ хоёр асуудалтай холбогдуулаад үг хэлэх гишүүд байвал нэрс авъя. Би тэгвэл нэг зүйл хэлнэ энэ дээр.

Тэгэхлээр Сүнжид дарга яг саяын ярьсан юун дээр энэ лицензтэй холбогдсон асуудал дээр иргэдээс Үндсэн хуулийнхаа үндсэн эрхийг хөндөж тэрийгээ үндэслэл болгож, гаргаж тавьж байгаа хүсэлт, гомдол бараг байхгүй байна гэж байна шүү дээ. Тэр чинь ер нь байхгүй байна гэж би ер нь сонсоод байна. Яг одоо та нэн кэйс байна уу? Надаа хэл дээ. Микрофоныг нь өгье.

**Д.Сүнжид:** Ховд, Эрдэнэт хоёроос яг уул уурхайн улмаас цагаан тоос үүсээд, бид нарын тэр уушиг, амьсгалын замын өвчлөлд нөлөөлж байна гэдгээ Эрдэнэтээс ярьсан. Ховдын “МонЭнКо”-оос тоосжилтын улмаас бид нарын амьдрах эрхэд бас нөлөөлөөд

байна гэдэг нь ирсэн. Энэ хоёр л байгаа юм. Орон нутгаас.

**Д.Цогтбаатар:** Яг үнэн. Тэгэхлээр би, наадах чинь ингээд төвлөрсөн, дандаа том хотуудаас, мэдээлэлтэй хүмүүс, хуульчид байж байгаа газруудаас ирээд байна шүү дээ. Тэгтэл энэ орон нутгаас өөр газраас ирэхгүй байна гэдэг юуг харуулж байна гэхлээр та бүгд маань энэ эрх чинь байгаа шүү ,энэ чинь Үндсэн хуульд суусан эрх, энийг хэн ч зөрчиж болохгүй, яг бодит энэ үйл ажиллагаагаараа яг саяын энэ тохиолдол ишг энэ Шинэжинстэд байгаа тохиолдол ишг зөрчих юм бол энэ эрх чинь байгаа шүү гэдгийг ард иргэддээ ойлгуулах ажлыг та нар маань маш сайн хийх хэрэгтэй юм байна гэсэн үг. Ард иргэд маань надад ийм эрх байгаа.

Тэгэхгүй бол амыг нь юугаар дарчхаад байна гэхлээр бусад органик хуулиудаараа бүх техник шаардлагуудаа хангачихсан, одоо ингээд болж байна гээд тулаад орж ирж байхад эцсийн хамгаалах бас энэ эрх зүйн гарц өнцөг байгаа шүү гэдгийгээ иргэддээ та нар сайн ойлгуулж, сургалт сурталчилгааг сайн хийж яваарай. Сая ягэнэ газруудаар бас Дондов гишүүн явж байлаа. Энэ сургалтаа бас хийж байгаа байх. Тэгэхлээр үүнийгээ орон нутгаар сайн хийж ер нь эрхийг нь таниулах хэрэгтэй юм байна шүү гэж бодсон шүү.

Ингээд энэ хоёр асуудлаар эрүүл, аюулгүй орчинд амьдрах асуудал мөн түүнчлэн Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаарх танилцуулгатай танилцаж дууслаа.

**Одоо Хүүхдийн эрхийн Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн Хүүхдийн эрхийн зарим асуудал сэдвийн талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Жаргалсайханы Хунан танилцуулга хийнэ.**

3 дугаар микрофон өгье.

**Ж.Хунан:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Хүний эрхийн Үндэсний Комиссын ээлжит 23 дахь илтгэлийн Хүүхдийн эрхийн зарим асуудалтай холбоотой мэдээллийг танд, та бүхэнд танилцуулъя.

Монгол Улс хүүхдийн эрхийг хангах чиглэлээр өөрийн хууль тогтоомжоо шинэ Үндсэн хууль болон Хүүхдийн эрхийн гэрээ конвенцод нийцүүлэх чиглэлээр бол тодорхой ажлуудыг бол хийж гүйцэтгэж, мөн тодорхой бүтцийг бий болгож байгаа хэдий ч зарим бүлгийн хүүхдүүд орхигдсон гэдэг ийм дүгнэлтийг хийсэн. Энэ дотроо бол хагас болон бүтэн өнчин хүүхдийн асуудал, мөн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудал бол үндсэндээ орхигдсон эдгээр хүүхдүүдийн эрх зөрчигдөж байна гэж бол дүгнэсэн байгаа.

2022 оны байдлаар Монгол Улсад 1282373 хүүхэд бүртгэлтэй байгаа бас 36363 хагас өнчин хүүхэд байна. 2911 бүтэн өнчин хүүхэд байна. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 12882 хүүхэд байна гэсэн ийм мэдээлэл бол байна. Эдгээр эмзэг бүлгийн хүүхдүүд рүү чиглэсэн тусгайлсан хөтөлбөр, бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө бол байдаггүй. 1997 онд бол яг тусгайлсан өнчин хүүхэдтэй холбоотой өөрөөр хэлбэл, Өнчин эцэг эхийн хараа хяналтаас гарсан хүүхдийн талаар авах зарим арга хэмжээний тухай бол тогтоол гарч байсан. Бусдаар, бусад батлагдсан хөтөлбөрт бол энэ бүтэн өнчин хүүхдийн асуудал, хагас өнчин хүүхдийн асуудал, байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн асуудал бол тусгагдах байдлаар бол явж ирсэн.

Хүний эрхийн Үндэсний Комисст ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, мөн энэ эдгээр бүлгийн хүүхдүүдийн чиглэлээр хийсэн судалгаа эд нарыг харахад бол өнөөдөр бид нар бүтэн өнчин, хагас

өнчин, байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй бол бүрэн гүйцэт бүртгэж чаддаггүй, хяналт тавьдаггүй. Үндсэндээ бол энэ тоо баримтууд, мэдээллүүд бол бүрэн дүүрэн гардаггүйгээс бол бодитой дүн шинжилгээ хийх боломж бол хязгаарлагдмал байна гэж бол үзсэн.

Мөн эдгээр бүлгийн хүүхдүүдийн асуудлыг тулгамдаж байгаа асуудаг нөхцөл байдлыг бол судалсан. Бас судалгаа бол улсын хэмжээнд бол тэр болгон байдаггүй юм байна. 2022 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бол яг бүтэн өнчин хүүхдийн аж ахуй байдлыг бол судалсан ийм судалгаа хийсэн. Мөн үүний мөрөөр авч хэрэгжүүлсэн ажил бол одоогоор бол байхгүй байна. Мөн энэ судалгааны үр дүнг бол олон нийтэд бол бас танилцуулагдаагүй байна гэж харж байна.

2022 оны байдлаар нийт 36363 хагас өнчин хүүхдээс 303 хүүхэд бүтэн өнчин, 2911 хүүхдээс 203 хүүхэд нь бол асрамж, халамжийн төвд бол бүртгэлтэй байна. Бусад хүүхдийн хувьд гэвэл асрамж, халамжийн төвд бүртгэлгүй, бүртгэгдээгүй 36060 хагас өнчин хүүхэд бол амьд сэрүүн байгаа эцэг эхийнхээ аль нэгний асран хамгаалалтад байдаг гэж үзвэл 2707 бүтэн өнчин хүүхэд албан ёсоор хэний асран хамгаалалтад хаана амьдарч ямар нөхцөлд амьдарч байгаа талаар бол мэдээлэл бол тэр байхгүй байна.

Эдгээр хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хувьд гэвэл асрамж, халамжийн төвд бүртгэлтэй хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалт бол бас хяналт доор байдаг учраас бол бүрэн гэж хэлж болохоор. Өөрөөр хэлбэл, асрамж, халамжийн төвүүдэд бүртгэлтэй хагас болон бүтэн өнчин хүүхдүүд 100 хувь ЕБС-д хамрагддаг бол цэцэрлэгийн насны хүүхдүүдийн 97 хувь нь бол цэцэрлэгт хамрагдсан гэдэг ийм мэдээлэл байна.

Харин асрамж, халамжийн төвд амьдардаг, тэнд сурдаг хүүхдүүд МСҮТ болон их, дээд сургуульд суралцах явдал нь бол бас учир дутагдалтай байна. Яагаад гэвэл их, дээд сургуульд суралцахаар элсэн орсон бүтэн өнчин, хагас өнчин хүүхдүүдийн төгсөлтийн байдлыг авч үзэхэд хангалттай. Өөрөөр хэлбэл их, дээд сургуульд сураад төгсөж байгаа хүүхдүүдийн бол тоо цөөн байна.

2019 оноос 2023 онд МСҮТ-д 277 хүүхэд суралцсанаас 61 хүүхэд, их, дээд сургуульд 195 хүүхэд суралцсанаас 20 хүүхэд нь л төгссөн байна. Ийм дүгнэлт, дүн бол гарч байгаа. Эндээс бол эдгээр хүүхдүүд 18 насанд хүрээд төрийн зүгээс өгч байгаа халамж бол зогсдогтой холбоотой байж болзошгүй, мөн энэтэй холбоотой гэж үзэж байгаа.

Хэдийгээр бүтэн өнчин, хагас өнчин хүүхдүүд их дээд сургуульд суралцах явцад их дээд сургуульд суралцах тэр төлбөрийн асуудлыг бол Боловсролын зээлийн сангаас бол харцуцаж байгаа ч суралцах хугацаандаа амьдрах тэр карманы мөнгө, бусад өдөр тутмын хэрэглээнд зарцуулах мөнгө байдаггүйгээс бол хөдөлмөр эрхлэх, сургуулиа хаях ийм нөхцөл байдалд хүрч, ийм учраас их цөөхөн хүүхэд бол төгсөж байгаа тэгээд. Тийм учраас энэ дээр бол их, дээд сургуульд сурч боловсрол эзэмших, цаашид бие даан амьдрахад энэ дээр бол бас бодлого тодорхой арга хэмжээ авах шаардлагатай гэж харж байна.

Нийгмийн халамжийн хуулиар бол хагас, бүтэн өнчин хүүхдүүд энэ хүүхдийн мөнгө авч байна. Дээрээс нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байна. Мөн онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид бол хамрагдаж байгаа.

Гэвч энэ тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа байдал нь бол бас төдийлөн бүрэн хүүхдүүдэд олгогдож

байгаа гэж үзэхэд бол учир дутагдалтай байгаа.

Тухайлбал, Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2021 онд тэжээгч нь нас барсан 16 хүртэлх насны 16300 хүүхэд бол тэтгэвэр авсан гэж мэдээ гаргасан. Нийгмийн даатгалын сангаас харин 19513 хүүхэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр авсан. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 915, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалаад өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулийн дагуу 476 хүн нийтдээ 37204 хүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр авсан гэж статистик мэдээ гарсан бол 2021 оны байдлаар нийт 39125 хүүхэд бүртгэгдсэн. Эндээсээ 1921 хагас болон бүтэн өнчин хүүхэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч чадаагүй буюу төрөөс халамж, туслалцаа авах эрх нь зөрчигдсөн гэж бол үзэж байгаа юм. Хүүхэд, залуучуудад нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу онцгой тохиолдлын болон амьжиргаагаа дэмжих мөнгөн тэтгэмжийг бол олгодог байгаа.

Гэвч энэ олгож байгаа байдал нь бол бүтэн өнчин хүүхдийн тодорхойлолтод заасан буюу Нийгмийн халамжийн тухай хуулиар бүтэн өнчин хүүхдэд ямар хүмүүст хамаарах юм бэ гэдэг заасан энэ шаардлагыг хангасан бүх хүүхэд бол авч чадахгүй байна гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, эцэг эх нь тогтоогдоогүй, эцэг эх нь сураггүй алга болсон, эцэг эх нь эрх зүйн чадамжгүй болсон эцэг эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан гэр бүл салсны улмаас асрамжтай авсан эх нь нас барсан 18-24 насны иргэн уг тэтгэмжийг бол авах боломжгүй байна.

Өөрөөр хэлбэл, энэ удаагийн онцгой тохиолдлын амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж нь эцэг эх нас барсан байхыг бол заавал шаарддаг учраас энэ

бусад бүтэн өнчин хүүхдийн ангилалд багтдаг энэ хүүхдүүд бол залуучууд энэ тэтгэмжийг авах боломж нь хязгаарлагдмал байна гэж үзсэн.

Хагас, бүтэн өнчин хүүхэдтэй холбоотой асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилох асуудал бол их чухал. Хүний эрхийн Үндэсний Комиссоос 5 аймгийн 20 сумын Засаг даргын 65 захирамж, мөн шүүхээс эцэг эх байх эрхийг хассан 28 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ бол хийсэн байгаа. Хийж үзэхэд хүүхдийг хэний асран хамгаалалтад үлдээж байгаа, хүүхдийн тэтгэвэр, хүүхдэд ноогдох өмч хөрөнгийн асуудлыг бол шийдвэрлэхгүйгээр орхигдуулсан ийм шийдвэрүүд бол гарсан байна. Энэ нь бол тухайн хүүхэд цаашид төрийн хамгаалалтад байх, төрийн халамж үйлчилгээг ав авах, дээрээс нь хяналт тавих, мөн өөрийн өмч хөрөнгийг хамгаалахад бол их учир дутагдалтай. Өөрөөр хэлбэл, эдгээр асуудлыг шийдээгүйн улмаас хэрх, яах нь бол тодорхойгүй ийм нөхцөл байдал үүссэн.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар 21 байгууллагын 30 асрамж, халамжийн төв байна. Үүнээс бол 4 аймагт буюу Дархан-Уул, Дорнод, Орхон, Өвөрхангай аймагт бол төрөлжсөн асрамжийн төв үйл ажиллагаа явуулж байна. Асрамж, халамжийн төвүүдийн хувьд бол улсын төсвөөс санхүүжиж байгаа асрамж, халамжийн төвүүдийн бол хангамж муу. Харин олон улсын байгууллага, эс үгүй бол томоохон аж ахуйн нэгжийн дэргэд байгаа асрамж, халамжийн төвүүдийн хангамж бол харьцангуй сайн байна.

Тэгээд энд бол улсаас, төрийн зүгээс бол бас дэмжлэг, туслалцаа бол шаардагддаг асрамж, халамжийн төвүүдтэй холбоотой энэ хөрөнгө оруулалтын асуудал бол бас төдийлөн хангалттай хийгддэггүйгээс тэнд орчин нөхцөл бол бас төдийлөн сайн биш гэдэг ийм дүгнэлтийг бол хийсэн байгаа. Асрамж, халамжийн төвүүдийг төрөлжүүлэх асуудал бол бас байна.

Учир нь асрамж, халамжийн төвүүд дээр орхигдсон, голлогдсон, хаягдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ирдэг. Мөн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ирдэг. Тэнд байрладагаас бусад хүүхдүүдийн эрүүл мэнд, амь насанд бас заналхийлэх ийм хортой нөлөө үзүүлэх ийм дүгнэлтийг бол хийж байгаа. Ийм асуудлыг бол асрамж, халамжийн төвүүдийн багш нар бас ярьж байгаа. Мөн бага насны хүүхдүүд ахлах ангийн сурагчид хооронд байх нь бол үе тэнгийн дээрлэлт, ахлах ангийн хүүхдүүд доод ангийнхныгаа бас дээрлэх ийм явдал бол бас гарч болзошгүй.

Тийм учраас эдгээр асрамж, халамжийн төвүүдийг нас насны ангиллаар нь төрөлжүүлэх бас ийм хэрэгцээ шаардлага байна гэж үзсэн. Байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд бас асуудлууд бол тулгамдсан хэд хэд байна. Тулгамдсан асуудал хэд хэд байгаа. Түрүүн хэлсэнчлэн асрамж, халамжийн төвүүдэд ихэнх тохиолдолд бол хаягдсан, хүнд хэлбэрийн хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд очиж байгаа. Эдгээр хүүхдүүдийг бол тусгайлан асрах, асран хамгаалах ийм асрамжийн төв байдаггүйгээс бол ердийн хүүхдүүдтэй хамт байдаг, эс үгүй бол одоо чиг үүргийн асран хамгаалах чиг үүргийн бус байгууллагуудад бол байрлаж, түр хамгаалах байр, төв сувилал, түр хамгаалах асрамж, халамжийн байрлаж байгаа нь байрлаж байдаг. Нийтдээ бол асрамж, халамжийн төвүүдэд нийтдээ 27 хүүхэд бол асрамж, халамжид бол байж байгаа.

2023 оны байдлаар 14127 хүүхэд бүртгэгдсэн байдаг. Эдгээр хүүхдүүд ихэнх нь бол эцэг эхтэйгээ хамт байдаг. Энэ мөн одоо эцэг эхтэйгээ хамт байдаг боловчиг өрхийн орлого, мөн эцэг эхийн хөдөлмөр эрхлэх боломж нь бол хязгаарлагдмал байдгаас мөн эмзэг байдалд ордог байгаа. Энэ байнгын

асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхэд чиглэсэн бол тусгайлсан хөтөлбөр бас байдаггүй юм.

Өөрөөр хэлбэл, эцэг эхэд нь сэтгэл зүйн болон бусад зөвлөгөө, туслацаа үзүүлдэг ийм тусгайлсан хөтөлбөр байхгүйгээс бол эцэг эхчүүд сэтгэл зүйн хувьд бол бас хямардаг. Мөн зарим тохиолдолд бас амиа хорлох тохиолдол гарч байсан гэдэг ийм зүйл бол эцэг эхтэй, эцэг эхийн төлөөлөлтэй хийж байх уулзалтын үеэр бол гарч байсан. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй холбоотой, мөн энэ асаргааны тэтгэмж, тэтгэврийн асуудал бол бас тавигдаж байгаа. Энэ нь нэгт тэгвэл энэ улсаас олгож байгаа халамж, тэтгэврийн хэмжээ бол хүрэлцээгүй нөхцөл байдал байдал болих хүндээр тусдаг.

2024 оны байдлаар бол халамжийн тэтгэврийг 375 мянган төгрөгөөр бол тогтоож нэмэгдүүлсэн байгаа. Асаргааны тэтгэмжийг бол 302500 төгрөг болж нэмэгдүүлсэн нь сайшаалтай ч яг бодит зардлыг харж үзэх юм бол энэ бол бас хангалтгүй гэдэг ийм дүгнэлтийг хийсэн байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн төлөөлөлтэй хамтран тооцоолол хийхэд сая 300 мянга орчим төгрөг бол зайлиггүй гарах доод зардал гэдэг ийм дүн бол гарсан байгаа.

Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тулгамддаг асуудал бол энэ хөгжлийн төвүүд байгаа. Өөрөөр хэлбэл, орон нутагт байдаг байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бол нийслэл хотод ирж энэ сувилал, мөн энэ хөдөлгөөн засах ийм эмчилгээ энэ дасгал сургуулилтад бол хамрагддаг.

Тийм учраас энэ тухайн өрхөд нэмэлт зардал, чирэгдэл болдог байгаа. Тийм учраас орон нутагт энэ хөгжлийн төвүүдийг, энэ хөдөлгөөн засал, хэл засал, энэ хөдөлмөр засал зэрэг энэ сургалтуудыг бол орон нутагт нь хийх ийм хэрэгцээ шаардлага бол байна гэж үзэж байгаа.

Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд дараагийн нэг тулгамддаг асуудал юу вэ гэвэл энэ. Эдгээр хүүхдүүдтэй ажиллах мэргэжлийн хүний нөөц бол хомс байдаг. Өөрөөр хэлбэл, сүүлийн 5 жилийн хугацаанд хэл засалч мэргэжлээр хүний нөөц бэлтгэгдээгүй гэсэн ийм мэдээлэл байгаа. Хөдөлмөр засалч мэргэжлээр 99 төгсөгч төгссөн зэргээс бол байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бол ажиллах хүний нөөц бол хангалтгүй байна гэдэг ийм дүгнэлтийг бол хийсэн байгаа.

Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тулгамддаг дараагийн нэг асуудал бол эм, эмийн хангамж, эмийн хүрэлцээний асуудал байдаг. Ихэнх тохиолдолд энэ эм оруулж ирэхэд бичиг баримтын бүрдүүлбэр бол хангахад их хүндрэлтэй байдаг. Мөн эмийн нөөцийн жагсаалтад ороогүйн улмаас бол эдгээр эмүүдийг оруулж ирэхэд бас хүндрэл учирдаг.

Тийм учраас эрүүл мэндийн сайдын 1 удаагийн зөвшөөрлөөр бол татан авалтыг бол хийдэг байгаа. Нийт 9 удаагийн татан авалтыг бол татан авалтаар бол эмүүдийг оруулж ирсэн. Гэсэн хэдий ч энэ хүрэлцээгүй. Орон нутгийн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэл бол хангалтгүй. Энэ эм ханган нийлүүлэх эм энэ хүүхдийн бүртгэл энэ нөөцийг бүрдүүлэх асуудлыг бас шийдвэрлэх ийм зайлиггүй шаардлагатай байна гэж. Эдгээр асуудлыг үндэслээд Хүний эрхийн Үндэсний Комиссоос дараах саналуудыг бол гаргаж байгаа.



Улсын хэмжээнд хагас болон бүтэн өнчин, байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийн статистик тоо мэдээллийг дэлгэрэнгүй гаргах, нэгдсэн санг бүрдүүлэх ийм шаардлага бол байна. Тийм учраас энийг бүрдүүлэхийг бол санал болгож байгаа, зөвлөж байна.

Мөн хагас болон бүтэн өнчин, байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийн нөхцөл байдлын судалгаа, дүн шинжилгээг бол тогтмол хийдэг болох ийм санал, зөвлөмжийг гаргаж байна.

Айлд амьдарч байгаа хагас болон бүтэн өнчин хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхиээлтэй хүүхэд рүү чиглэсэн дэмжлэг, туслалцааг үзүүлэх тусгайлсан хөтөлбөр ажлыг гарган хэрэгжүүлэх, мөн хяналтыг сайжруулах ийм санал, зөвлөмжийг гаргаж байгаа.

Шүүхийн шийдвэрээр эцэг эх байх эрхээ хязгаарлуулсан хасуулсан хугацаанд төрөөс хүүхдэд тэжээгчээ алдсаны тэтгэмж олгох зохицуулалтыг бол нэмж бий болгох бас шаардлагатай байна гэж харсан. Тийм учраас энийг бас зөвлөж санал болгож байна.

Бүтэн өнчин хүүхдийн тодорхойлолтод багтаж байгаа хүүхэд бүрд асрамж, халамжийн төвд байгаа эсэхээс үл хамааран тэтгэвэр тэтгэмжийг хагас өнчин бүтэн өнчин болсон өдрөөс тооцон олгох энэ зохицуулалтыг бол бий болгох, шүүхээс эцэг эх байх эрхийг нь хассан хязгаарлаж буй шийдвэрт хүүхдийн асуудлыг бүрэн хэмжээнд хүүхдийн аюулгүй байдал, өмч хөрөнгө, эрүүл мэнд, боловсролын асуудлыг бол шийдвэрлэдэг байх практикийг нэвтрүүлэх, хагас болон бүтэн өнчин болж буй хүүхдийн өмч хөрөнгийг хамгаалах өөрөөр хэлбэл, өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах зохицуулалтыг бол боловсронгуй болгох, хагас болон бүтэн өнчин хүүхдэд сэтгэл зүй сэтгэл заслын үйлчилгээг үр дүнтэй

цогц байдлаар үзүүлэх, хагас болон бүтэн өнчин хүүхдэд төрөөс олгож буй тэтгэвэр дэмжлэг туслалцааг нэмэгдүүлэх ийм санал зөвлөмжийг бол гаргаж байгаа.

Асрамж, халамжийн төвөөс гарч буй бүтэн өнчин хүүхдийг ажлын байр, орон байртай болгоход бодитой дэмжлэг үзүүлэх. Боловсролын зээлийн санхүүжилтээр их, дээд сургуульд суралцаж буй хагас бүтэн өнчин хүүхдүүдэд тэтгэлэг олгох асуудлыг бол шийдвэрлэх ийм санал, зөвлөмжийг гаргаж байна.

Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийн эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, орон сууцын хөнгөлөлтөд хамруулах арга хэмжээг авах ийм санал, зөвлөмжийг гаргаж байна.

Байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийн эцэг эхийн сэтгэл зүй болон сэтгэл заслын үйлчилгээнд тогтмол хамруулах тусгай хөтөлбөрийг бол гаргаж хэрэгжүүлэх ийм санал, зөвлөмжийг гаргаж байгаа.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийг асарч байгаа иргэний асаргааны тэтгэмжийг бодитой тооцож хэрэгцээнд нь тулгуурлаж тогтоох ийм санал, зөвлөмжийг гаргаж байгаа.

Уналт, таталтын эсрэг эмийн нөөц хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутагт түгээх, шуурхай түгээх ийм тогтолцоо механизмыг бий болгох.

Бүртгэлтэй эмийн жагсаалтад багтсан эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх даатгалд бүрэн хамруулах энэ санал, зөвлөмжийг гаргаж байна.

Аймаг, дүүрэг бүрд байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд зориулсан нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, боловсрол

олгох өдөр өнжүүлэх зориулалттай хөгжлийн болон арга зүйн төвийг бол байгуулах, холбогдох санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг бол ишидвэрлэх ийм санал зөвлөмжийг гаргаж байгаа.

Мөн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан төрөлжсөн асрамж, халамжийн төвийг нэн яаралтай байгуулах. Мөн хагас болон бүтэн өнчин хүүхдийн асрамж, халамжийн төвийг төрөлжүүлэх ийм санал, зөвлөмжийг бол гаргаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа.

Энэ Хүүхдийн эрхийн асуудлаарх Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн Гэр бүлийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал сэдвийн талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Хүрэлбаатарын Мөнхзул танилцуулсны дараа нэгтгээд түрүүнийх шигээ асуулт, хариултаа явуулаад, үгээ хэлье гэж бодож байна.

Тэгэхлээр Хүрэлбаатарын Мөнхзул гишүүн нэг асуудал танилцуулахыг урьж байна. 3 дугаар микрофон.

**М.Мөнхзул:** Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Тэгэхээр сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүрээнд ялангуяа хүүхдийн эсрэг үл хайхрах асуудал, бэлгийн хүчирхийлэл гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж байгаа. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссоос Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг 2 жил тутам Улсын Их Хуралд тайлагнах энэ чиг үүргийнхээ хүрээнд бид нар энэ жил анх удаа гэр бүлийн хүрээнд дэх энэ жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хуульд заасан 7 багц асуудлын хүрээнд тайлагнаж байна.

Энэ дээр гэрлэлт, гэрлэлт цуцлах тэгш эрхийн асуудал, гэр бүл дэх эрх мэдлийн хуваарилалт ямар байна? Өөрөөр хэлбэл, хүчирхийллийн асуудлууд, хүүхдээ өсгөн хүмүүжих эцэг эхийн хамтын үүрэг, хариуцлагын асуудал, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн асуудал, гэр бүл дэх хөлсгүй хөдөлмөр, гэр бүлийн боловсрол, сүүлийн жилүүдэд бас гэр бүлийн хэв маяг өөрчлөгдөж байгаа. Үүнийгээ дагаад бас онцлог хүний эрхийн асуудлууд үүний цаана яригдаж байгаа гээд ингээд 7 багц асуудлын хүрээнд энэхүү илтгэлээ та танилцуулж байна.

Гэрлэлт гэрлэх, цуцлах тэгш эрхийн хүрээнд анхаарал татаж байгаа асуудал нь сүүлийн 10 жилийн дунджаар Монгол Улсын 4 гэр бүл тутмын 1 гэр бүлээ цуцлуулж байна гэсэн ийм тоо баримт харагдаж байна. Тэгэхээр энэ дээр ялангуяа гэр бүл салсны дараа хоорондоо бие биеэ үзэн ядах энэ байдлаас улбаатайгаар үр хүүхдээ уулзуулахгүй байх, үл хайхрах энэ асуудал бол энэ гэр бүл цуцлалтын ард, хүүхдийн эрх ашиг ноцтойгоор зөрчигдөж байна.

Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссоос энэ гэр бүл цуцлалтын талаар суурь шалтгаан нь ямар байна вэ гэдэг дээр аваад үзэхэд 74.8 хувь нь хамгийн өндөр буюу зан харилцааны таарамжгүй байдал, мөн бусад гэсэн энэ үзүүлэлтүүд дийлэнх хувийг нь эзэлж байна. Үүний цаана яг ямар шалтгаан ба нуугдаад байгаа юм бэ гэдэг дээр нарийвчилсан тоо, статистик хийгдээгүй байна. Тэгэхээр энэ гэр бүл цуцлалтын хамгийн суурь шалтгаан болох энэ зан харилцааны таарамжгүй байдал тэгвэл ийм их өндөр байгаа юм бол өнөөдөр энэ хосуудад өгч байгаа энэ зөвлөгөө, сэтгэл зүйн зөвлөгөө гэхэд анхан шатад байхгүй, байсан ч юу үнэ нь маш өндөр ийм байна.

Тийм учраас энэ гэр бүл цуцлалтын энэ шалтгаан, нөхцөлийг нь судалж энийг арилгахад чиглэсэн арга хэмжээ хангалтгүй байна гэж дүгнэсэн.

Хоёрт нь энэ гэр бүл дэх эрх мэдлийн хуваарилалт гээд. Сүүлийн жилүүдэд цагдаагийн байгууллагын статистик мэдээллээр ингээд харахад гэр бүлийн хүчирхийллийн асуудал дээр ихэнх тохиолдолд бие махбодын хүчирхийллийн асуудал бүртгэгдэж энэ чиглэлийн статистик тоо баримтаас төдийлөн бас буурахгүй байгаа ийм дүн харагдаж байна.

Харин сэтгэл санааны хүчирхийлэл, эдийн засгийн хүчирхийллийн асуудал бас төдийлөн мэдээлэгдэхгүй. Энэ талаар бас цагдаагийн байгууллагын чадавх, хүч бас сул байгаатай холбоотой ийм асуудлууд үүссэн байна. Жишээлбэл, судалгаагаар энэ сэтгэл санааны хүчирхийлэл буюу 5 эмэгтэй тутмын 2 нь хянах хэлбэрийн хүчирхийлэлд өртөж байна.

Сүүлийн жилүүдэд одоо энэ интернэтэд нь цахим энэ технологи өсөж байгаатай холбоотойгоор хянах хэлбэрийн аппликэйшн ашиглаж бие биеэ хянах, ажил төрлийг нь хийлгэхгүй байх бусад нийгмийн амьдралд оролцохыг нь хязгаарлах гээд ийм зөрчлүүдийг байгаа гэдэг ийм статистик байгаа ч гэсэн энэ дээр одоо яг зөрчлийн хэмжээнд, гэмт хэргийн хэмжээнд шийдэгдээд явж байгаа ийм статистик байхгүй байна.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн асуудал бол төрөөс бас тодорхой арга хэмжээнүүдийг авч, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Гэсэн хэдий ч гэр бүлийн хүчирхийллийн статистик дүнгээс харахад төдийлөн буурахгүй байна.

Буурахгүй байгаагийн гол шалтгаан нь гэр бүлд чиглэсэ, яг энэ гэр бүлийн хүчирхийллийн суурь шалтгааныг арилгахад чиглэсэн урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй байна.

Нөгөө талаар хүчирхийлэл үйлдэгсдэд оногдуулж буй энэ

хариуцлагын механизмаа бас эргэн харах, зөрчлийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн өмнөх шатад шүүхийн шийдвэрээр хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нь нөлөөлөхөд чиглэсэн гэр бүлийн тэр өвөрмөц онцлогт нь нийцсэн ийм шаталсан хариуцлагын механизмыг бий болгох зайлишгүй шаардлагатай байна гэж харж байна.

Нөгөө талаар гэр бүлийн хүчирхийллийн нийгмийн эрүүл мэндэд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн судалгааг Эрүүл мэндийн яам хийх үүрэгтэй ч одоогоор огт хийгдээгүй өнөөдөр Монгол Улсад энэ гэр бүлийн хүчирхийлээс болоод хэдэн хүн хөгжлийн бэрхшээлтэй болсон юм, хэдэн хүн амиа хорлосон юм, хэдэн хүн гэмтэл авсан юм гэдэг ийм нарийвчилсан судалгаа байхгүй байна.

Тэгэхээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийллийг нийгмийн эрүүл мэндийн асуудал гэж тодорхойлоод ингээд байхад эрүүл мэндийн салбар энэ талын оролцоо сул байна гэж харж байна. Хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх эцэг эхийн хамтын хариуцлага өнөөдөр сул байна. Эцэг эхчүүдийн дунд ингээд судалгаагаар харахад хүүхдээ буруу зүйл хийвэл зодох ёстой гэсэн энэ хэвмэл ойлголт хэвээр байна. Илүү эцэг эх үүрэг, хариуцлагаа сургууль багш нарт оногдуулж байна гэсэн ийм судалгааны дүн гарч байгаа.

Тэгэхээр энэ дээр энэ эцэг эхийн үүрэг, хариуцлагыг сайжруулах, ялангуяа энэ хүүхдийн тэтгэвэр төлж байгаа асуудал маш хангалтгүй байгаа 57.7 хувь нь тэтгэлэг төлөгдөөгүй байх жишээтэй. Тэгэхээр бид нар энэ гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаар яаралтай батлуулж, эцэг эхийн тэжээн тэтгэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй эцэг эхэд хариуцлагыг чангаруулах асуудал зайлишгүй шаардлагатай байна. Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүй дээр анхаарал татаж байгаа асуудал нь энэ өсвөр насны охидын жирэмслэлт, үр

хөндөлт, бэлгийн замын халдварт өвчин маш, бас статистик тоо баримтууд их байна. Жишээлбэл, 10-19 насны хүүхэд бол 2022 онд 2391 хүүхэд одоо төрсөн байх жишээтэй.

Гэр бүл дэх хөлсгүй хөдөлмөрийн асуудал гээд. Энэ дээр эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт эрэгтэйчүүдтэй харьцуулахад 3 дахин илүү цаг зарцуулж байгаа. Хүний эрхийн Үндэсний Комиссоос энэ байнгын асаргаа шаардлагатай иргэдийн асарч буй эмэгтэйчүүдийн тоог ингээд аваад үзэхэд эрэгтэйчүүдээс 3.5 дахин өндөр байгаа.

Тэгэхээр энэ төрөлтийн түвшин нэмэгдэх хэрээр эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн оролцооны түвшин буурч байгаа ийм статистик байгаа. Тэгэхээр мэдээж хүн амын шилжилтийн үйл явц эрчимтэй явагдаж байна. Насжилт өсөх, насжилт настай хүмүүсийн тоо өсөх хандлагатай байгаа энэ цаг үед бид нар угтах стратеги, бодлогоо тодорхойлох хүрээнд урт хугацааны даатгалын тогтолцоог Монгол Улсад хуульчлах шаардлагатай байна.

Нөгөө талаар, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй өндөр настныг асарч байгаа олон нийтэд түшиглэсэн хөтөлбөрүүдийг бий болгож, энэ талаарх хөрөнгө оруулалт, санхүүжилтийг бий болгох зайлшгүй шаардлагатай байна. Гэр бүлийн боловсрол олгож байгаа асуудал бол бүх түвшинд хангалтгүй байна. Эцэг эх ялангуяа ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт эрүүл мэндийн чиглэлээр орж байгаа хичээл нь гэхэд маш хангалтгүй.

Жишээлбэл, эцэг эх байх үүрэг хариуцлагын хичээл зөвхөн 1 цагийн л хичээл байгаа нь ирээдүйд хариуцлагатай эцэг эх байх төлөвшлийг бүрэн олгож чадахгүй байна гэж үзэж байна.

Хүүхэд, гэр бүл хөгжлийн хамгааллын ерөнхий газраас гэр бүлийн боловсрол олгож байгаа ч энэ нь анхан

шатад нэгжгүй учраас иргэдийн эрэлт, хэрэгцээг хангаж чадахгүй байна. Хүний эрхийн Үндэсний Комисс энэхүү илтгэлээрээ нийт 15 хэв шинж бүхий гэр бүлийн асуудлыг гаргаж тавьсан байгаа. Энэ дээр ялангуяа зорилтот гэр бүлийн асуудал, архины хамааралтай, байнгын архины хамааралтай, байнгын хүчирхийлэлтэй, малчин гэр бүлийн асуудал бас онцгой анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байна. Эдгээр гэр бүлийн асуудлын цаана өвөрмөц хүний эрхийн асуудал, өвөрмөц үйлчилгээ гэр бүлд чиглэсэн ийм ялгаатай хэрэгцээ шаардлагууд байна.

Тийм учраас ялангуяа энэ давхар асуудалтай гэр бүлүүд буюу хөгжлийн бэрхшээлтэй хэр нь байнгын үр хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй хэр нь байнгын хүчирхийлэлтэй ч гэдэг юм уу, архины хамааралтай, олон хүүхэдтэй гээд ийм давхар асуудалтай гэр бүлийн асуудлыг өнөөдөр судалсан статистик тоон мэдээлэл бол байхгүй байна. Ингээд нийтдээ 6 зөвлөмжийг хүргүүлж байна.

Нэгдүгээрт, энэ гэр бүлийн боловсрол олгох, орон байраар хангах, зорилтот гэр бүлийг дэмжих, нийгмийн үйлчилгээг сайжруулах, хүчирхийллийн ахуйн хүрээний сөрөг зан үйлээс хамгаалах асуудлыг тусгасан гэр бүлд чиглэсэн салбар дундын цогц бодлого батлах санхүүжилтийг ишидвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

Хоёрт нь гэр бүлийн боловсролыг бүх шатад олгох асуудлыг албан ба албан бус тогтолцоогоор иргэн, төр, иргэний нийгмийн байгуулал зүйн тохь тогтолцоог тодорхой болгож, холбогдох байгууллагад хариуцуулах, энэ ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа энэ асуудлыг, асрах үйлчилгээг даатгалын зарчмаар санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж хэрэгжүүлэх.

Гэр бүл, хүүхдийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох.

Өсвөр насны нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд онцгой анхаарал хандуулж тэдний өвөрмөц хэрэгцээнд тулгуурласан урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний тусгай арга хэмжээ авах,

Шүүхээс тогтоосон хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн хүүхдээ тэдэн ч тэтгэх үүргээ биелүүлээгүй эцэг эх хамгаалах, хүлээлгэх хариуцлагыг чангатгах.

Төлбөрийн чадваргүй тэтгэлэг төлөгчдийн үүргийг нөхөн төлөгдөх нөхцөлтэй хүүхдийн тэтгэлгийн сангаас олгох боломжийг судлах гэсэн ийм 6 саналыг хүргүүлж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Мөнхзул гишүүн асуудлаа танилцуулж дууслаа. Ингээд энэ сая танилцуулсан асуудлуудтай холбогдуулаад асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Байхгүй байна. Үг хэлэх гишүүд? Би өөрөө үг хэлнэ.

Энэ дээр ийм зүйл байна Сүнжид дарга, Мөнхзул гишүүн аль аль нь анхаарах зүйл байгаа. Би энэ дээр яг тодорхой асуудал ярьж гэж бодож байна.

Юу гэвэл энэ жендерийн асуудалтай холбоотой, жендер сая гэр бүлийн хүрээнд та нар ярьсан биз дээ тээ? Тэгэхлээр энэ дээр ийм асуудал байгаа. Ер нь энэ гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдолтой, жендерийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхах энэ асуудлууд сүүлийн үед Монголд стресс нэмэгдсэнтэй холбоотой юу нэлээн гарч байна. Тэгэхлээр энэ сэтгэл зүй судлал тал дээр Хүний эрхийн Комисс онцгойлон анхаарч, та нар өөрсдөө энэ МУИС-ийн сэтгэл зүйн танхим эд нартай хамтарч энэ хамтарсан судалгаа хийх онцгой шаардлага байна. Нэг.

Хоёрт, Нэг зүйл хэлмээр байна. Одоо яг амьдрал дээр гарч байгаа зүйл. Манай Сүхбаатар дүүргийн дуучин нэг эмэгтэй Хууль зүйн байнгын хороонд гомдол гаргасан. Ингээд ерөнхий юм ярилгүй би яг тодорхой кэйс ярих гэж байна шүү дээ. Танай Хүний эрхийн Комисс дээр бас гомдол гаргасан байгаа юм байна лээ. Ингээд энэ асуудлыг аваад, хэлэлцээд явж байхад энэ асуудал нь шүүх дээр оччихсон байж байгаа байхгүй юу. Тэгсэн чинь би с саяхан надаа өөрийнх нь холбогдох яамнаас албан тоот ирүүлсэн байна. Сүнжид дарга үүнийг та нар анхаарах хэрэгтэй. Шүүх дээр асуудал нь оччихоод байхад яам нь ядаад хариу ирүүлэхдээ тэгвэл наадах чинь шүүх дээр байгаа бол бид энэ дээр одоогоор ямар нэгэн байр суурь илэрхийлэхгүй гэж хариулах ёстой биз дээ?

Тэгэхэд энэ асуудлуудыг чинь ингээд аваад хэлэлцлээ энээ тэрээ, тэр асуудал дээр нь ямар нэгэн асуудал байхгүй байгаа юм байна. Энэ дээр нь танайх Ёс зүйн хороогоороо авч хэлэлцээд шийдчихсэн байна. Үгүй энийг чинь нөгөө тал н шүүх дээр шууд аваад хэрэглэх асуудал болж хувирч байна шүү дээ. Энэ чинь шүүхэд хажуугаас нь шууд нөлөөлөхүйц төрийн байгууллагаас оролцоо орж ирж байна гэсэн үг байхгүй юу. Ийм жендерийн мэдрэмжгүй ийм нөхцөл байдлыг үнэхээр зогсоох хэрэгтэй. Тэр ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой энэ асуудлууд дээр би юу хэлмээр байна гэхлээр би өөрөө энэ Улсын Их Хурлын нэр дэвшигчдийн эмэгтэй нэр дэвшигчдийг 30 хувь байх ёстой энэ 24 оны сонгуульд, дараа нь 28 оны сонгуульд 40 хувь болгох ёстой гээд дэмжээд зүтгэсэн цөөхөн эрэгтэй гишүүдийн нэг. Цөөхөн эрэгтэй гишүүний. Мааш их хэл амны ард гарч байж бид нар дэмжиж гаргасан.

Тэгэхэд одоо ингээд жендерийн асуудал ярихлаар хэдэн дарга эмэгтэйчүүдийн тухай яриад байх юм. Би жишээлбэл энийг дэмжихдээ дарга

эмэгтэйчүүдийг олон болгох гээгүй. Тэр эмэгтэйчүүд олон болж бусад энэ дээрлхүүлж байгаа, эрх нь зөрчигдөж байгаа эмэгтэйчүүдээ хамгаалдаг эмэгтэйчүүдийн тоо ихсээсэй гэж энийг хийж байгаа байхгүй юу.

Тэгэхлээр энэ дээр танайх ч гэсэн хатуу ярьж, дуугарах ёстой. Энэ дээр та нар хатуу байр суурьтай байх ёстой. Зөндөө эмэгтэй дарга нар байна. Энэ эмэгтэйчүүдийнхээ асуудлаар дуугарахгүй байгаад байна гэдэг чинь байж болохгүй зүйл. Би Хүний эрхийн Комиссоос яг тодорхой хүмүүс дээр хэдэн хүн дээр хариуцлага тооцсон бэ гээд танайхаас мэдээлэл авсан. Энэ бас сэтгэлд хүрэхгүй байна.

Яагаад гэвэл зүгээр та нар ингээд тоо явуулсан байна. Хэдэн хүнд яг, би энэ та нарын тавьсан зөвлөмжийг нийт 87 байх шиг байна лээ л дээ. Ерөнхий биелсэн нь 80 хувь гэж нэлээн өндөр л гарч байна. Монголд хүний эрхийн байдал тийм айхтар сайн байгаа юм шиг л. Одоо зөвхөн энэ үзүүлэлтээр аваад үзэхэд. Өөр олон үзүүлэлтээр өөр байж болно. Тэгвэл тэр 80 хувь гэхэд цаана нь 20 хувь биелүүлээгүй байгаа нөхдүүд тэр хэн хэн юм бэ? Тэр хүмүүсийг энэ танай тайланг хэлэлцээд энэний дагуу тогтоол гарна шүү дээ.

Их Хурлын тогтоол гарахад тэр тогтоолыг хэлэлцэх үеэр ер нь тэр биелүүлэхгүй, та нарыг шаардлага тавиад, өөрийнхөө албан байгууллагад урихад ирдэггүй, үл тоомсорлодог, та нарын тавьж байгаа шаардлагыг биелүүлдэггүй хүмүүс хэн юм бэ? Яг тэр нэрийг нь заагаад, дараагийн энэ Байнгын хороон дээр тэр хүмүүсийг авчир. Тэгээд энд асууя. Яагаад хүний эрхийн асуудал дээр ингэж хандаад байгаа юм? Тэр өчигдөр өөр Байнгын хороон дээр бас асуудал хэлэлцэгдэж байгаад гацсан, дараагийн юу руу хойшлогдсон байна лээ.

Тэгэхлээр иймэрхүү хүний эрхийн асуудал дээрээ бид нар хаа хаанаа ингэж

хандаад байхгүй, цаг тухайдаа юмнуудаа хийгээд явдаг байх ёстой. Би энэ дээр тэр жендерийн асуудал дээр ялангуяа мэдрэмжтэй байх хэрэгтэй байна. Одоо яг миний энэ саяын хэлсэн асуудлаар тэр шүүх процесс явж байхад холбогдох яаманд тийм бичиг өгч байгаа чинь хууль зөрчиж байна уу, үгүй юү гэсэн энэ асуудал дээр надад тайлбар ирүүлээрэй. Яг энэ хүн дээр танай дээр гомдол гаргасан юм байна лээ тэр дуучин эмэгтэй. Тэн дээр та нар яг ямар ямар арга хэмжээ авсан юм? Үүнийгээ надаа тодорхой тайлан өгөөрэй гэж би хэлмээр байна.

Гэр бүлийн Харилцаан дахь жендерийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудлын талаарх Мөнхзул гишүүний танилцуулга, Хунан гишүүний Хүүхдийн эрхийн асуудлаарх танилцуулгуудыг тус тус хэлэлцлээ.

Асуулт асууж, хариулт авлаа. Үг хэлэх гишүүд нь үг хэллээ. Дараагийн асуудалдаа оръё.

**Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн Иргэний нийгэм болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилт, сэдвийн талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрх хамгаалагчийн хэлтсийн дарга Өнөржаргал танилцуулна.**

Өнөржаргалын микрофоныг өгье. Хэддүгээр микрофон байна? Та 3 дугаар микрофон руу суучих. 3 дугаар микрофон өгье.

**3.Өнөржаргал:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаад 3 жил болж байгаа. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлыг жил бүр Улсын Их Хуралд илтгэлээр дамжуулж илтгэх ийм үүрэгтэй байгаа.

Бид нар энэ удаагийн илтгэлээр болохоор Иргэний нийгэм болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилтийг бичсэн байгаа. Энэ дээр ер нь энэ бүлэгт бүлэг Хүний эрх хамгаалагчдын хүний эрх хамгаалах үйл ажиллагааны онцлог нь ямар байна? Тэдэнд учирч байгаа бэрхшээл, эрсдэлээ яаж даван туулж байна? Ялангуяа энэ байгаль орчны чиглэлээр ажиллаж байгаа тэргүүн шугамд ажиллаж байгаа хүний эрх хамгаалагч буюу байгаль хамгаалагч, экологийн цагдаа, тэрийг дагаад ажиллаж байгаа иргэний нийгмийн хүний эрхийн хамгаалагчдын гүйцэтгэж байгаа үүрэг, ач холбогдол нь ямар байна? Бид энэ хүмүүсийн аюулгүй байдал, хамгаалалтын талаарх Монгол улсын нөхцөл байдалд нь ямар асуудлууд тулгарч байна? Цаашид бид ямар дүгнэлт, саналыг гаргах вэ гэдэг талаар нь илтгэлээрээ энэ дүгнэлт, саналаа дэвшүүлсэн байна.

Тэгэхээр бид нар энэ илтгэлийн энэ бүлгийг боловсруулахдаа нийтдээ социологийн судалгаа, шүүхийн шийдвэрийн кэйс, ярилцлагын кэйс, бусад тэр нөгөөдөх албан эх сурвалжууд буюу тэр Комиссын гишүүний гаргасан, зөвлөмж, дээрээс нь Комиссын дэргэдэх орон тооны бус хүний эрх хамгаалагчийн хорооны дүгнэлтэд ингэж бас тулгуурлаж энэ илтгэлийг бичсэн. Мөн олон улсын индекс, олон улсын судалгааны харьцуулж бас боловсруулсан байгаа.

Ерөнхийдөө бид нар Монгол Улсад 31 мянган иргэний нийгмийн байгууллага бүртгэлтэй байгаагаас яг цэвэр үйл ажиллагаа явуулж байгаа нь 7 мянга идэвхтэй үйл ажиллагаа явуулж.

Ер нь олон улсын индексээр авч үзэхээр манай Монгол Улсын иргэний нийгмийн байгууллагуудын дэлхийн холбооны индексээр авч үзэхээр 100 онооны үлдэгдэл дээр ингээд аваад үзэхээр энэ иргэний нийгмийн

байгууллагуудын оноо дандаа буурсан үзүүлэлттэй байдаг. Ноднингийнх дээр ахисан үзүүлэлттэй. Тэр нь ямар учиртай вэ гэхээр Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль гарснаараа ахиц гарсан.

Гэхдээ хүний эрхийн суурь үзүүлэлтүүд өөрөө сайнгүй байгаагаас хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдал нь бас дагаад адилхан гэсэн буурсан тийм үзүүлэлттэй байдаг юм байна гэж гарсан байгаа.

Тэгэхээр энэ манай энэ иргэний нийгэмд ажиллаж байгаа хүний эрх хамгаалагчдын яг эрх зөрчигдөж байгаа. Тийм асуудал нь ямар байна вэ гэхээр уул уурхай, байгаль орчны чиглэлээр ажиллаж байгаа хүний эрх хамгаалагчдын эрх нь зөрчил маш их байдаг. Тэдэнд учирч байгаа аюул, эрсдэл, заналхийлэл, дарамт шахалтын асуудлууд нэлээдгүй байна гэдэг нь гарч ирсэн байгаа. Мэдээж дараагийнх нь жагсаал цуглаан, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шударга ёсыг шаардах, эмэгтэйчүүдийн эрх гэсэн энэ асуудал дээр бас нэлээдгүй эрх нь дарамт, шахалт ирдэг. Ямар нэгэн заналхийлэл, аюул эрсдэлтэй бид тулгардаг гэдэг асуудлыг ярьж үзэж байгаа.

Тэгэхээр байгаль орчны чиглэлийн асуудал дээр болохоор байгаль хамгаалагчдын статус ерөөсөө тод тодорхой бус байгаа нь өөрөө хууль тогтоомждоо тодорхой бус байгаа нь энэ бас дагаад энд иргэний нийгмийнхээ хүний эрх хамгаалагч нарт бас асуудал үүсдэг.

Яагаад вэ гэхээр нэгдүгээрт Байгаль орчны яаманд, Монгол Улсад 1147 байгаль хамгаалагчид байгаа бөгөөд Тусгай хамгаалалттай харьяалалтай, дээрээс нь орон нутагтаа харьяалалтай, нийслэл, аймаг, сумд гээд. Тэгэхээр эд нарын статус үйл ажиллагаа нь ингээд 9 хуулийн хэрэгжилт, 20 гаруй журмын хэрэгжилтэд ингэж байгаль хамгаалах үйл ажиллагаагаа явуулах ёстой байтал

эд нарын харьяалал нь ингээд өөр байгаагаас ялгаатай байдлууд их үүсэж байна. Үүнийгээ дагаад тэнд ажиллаж байгаа иргэний нийгмийн байгууллагуудын хүний эрх хамгаалагчдын дэвшүүлж тавьсан асуудал шийдэгддэггүй гэсэн ийм бас тогтолцооны шинжтэй асуудлууд байна.

Тэгээд энэ дээр нь болохоор байгаль хамгаалагч гэдгийг хуулиар тодорхойлоогүй. Дээрээс нь байгаль хамгаалагч Эрүүгийн хуульдаа болохоор хууль сахиулагчийн статусаар ингээд ажиллана гээд заачихсан. Тэгтэл одоогийн бодит нөхцөл байдал дээр байгаль хамгаалагч үнэхээр хууль сахиулагчийн статусаар ажиллах ямар ч нөхцөл байдал байхгүй. Тэр хүмүүс ялангуяа Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагч нар ингээд гүний эргүүлээр яваад ингээд хээр хөдөөгөөр ингээд байгаль хамгаалах үйл ажиллагаагаа явуулдаг мөртөө Зөрчлийн хуулиар эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Тэгэнгүүтээ 7 хоногт 40 цагаар ажиллах байтал тэр цаг нь 60-80 цагаар илүү ачаалалтай, ерөөсөө ингээд 3 хоногтоо ЭБАТ-ыхаа ажлыг хийх гээд цаашаа тэр яг үндсэн үүргээ гүйцэтгэж чаддаггүй ийм нөхцөл байдлууд байна.

Тэгээд энэ ингээд байгаль хамгаалагч нар, экологийн цагдаагийнхаа хороондоо ажиллаад ингээд байгаль орчны эсрэг ингээд гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхээр хамгийн их ингээж орон нутагт аюул заналхийлэл, өс хонзонгийн сэдэлтэй дарамт шахалтад өртдөг байгаа юм. Үүний хамгийн тод жишээ нь юу вэ гэхээр яг ажлын байрны орчин байхгүй. Гэрээрээ байгаль хамгаалах ажлыг хийгээд тэгэнгүүт нь гэрт нь ирээд иүүд нөгөөдөх архи уугаад ирж зодож байгаа. Тэгэнгүүтээ хэрэг бүртгэлд ингээд үүсэх гэхээр танд та энэ чинь өөрөө ажлын байран дээрээ байгаагүй байна гэдэг асуудал ярьж байгаа.

Тэгэхээр байгаль хамгаалагчдыг ажлын байр нь гэр нь гэж үзэх үү гээд ийм ойлгомжгүй, тодорхойгүй асуудлууд бас их гарч байна гэдгийг энэ манай судалгаан дээр юу гарч ирсэн байгаа. Мэдээж байгаль хамгаалагчдын тэр хувцас, хэрэглэл нь одоогийн байдлаар улсын төсвөөс мөнгө гаргахгүй, олон улсын дэмжлэгээр ингээж санхүүжилтийн дэмжлэгээр явж байгаа. Энэ Тусгай хамгаалалттай газар нутгийнх. Энэ дээр орон нутгийнх нь асуудал нь бас ингээд тодорхойгүй тэнд байгаа байгаль хамгаалагч нар болохоор бараг л хог хаягдал тийм асуудлуудыг шийдэх тал дээр их түлхүү ажилладаг гэдэг юм нь гарч ирсэн байгаа.

Дараагийн асуудал нь Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль гарснаараа энэ чинь ерөөсөө аюул, эрсдэл учирсан хүний эрх хамгаалагчдыг хамгаалах, тэр аюул эрсдэлээс нь зайлуулах, ялангуяа амиа хорлоё гэсэн сэтгэхүйтэй болчихсон тэр хүмүүсийн сэтгэл санааны дэмжлэг ийг өгөхөд хамгийн гол чухал үүрэгтэй ажиллаж байгаа.

Тэгэхээр нэгдүгээрт нь энэ ер нь хүний эрх хамгаалагчид өөрсдөө сайн дурын үндсэн дээр, эсвэл мэргэжлийн үйл ажиллагаагаараа, иргэний нийгмийн гэсэн ийм 3 статусаар үйл ажиллагаагаа Монгол Улсын хэмжээнд явуулж байгаа. Тэгтэл яг тэр хүмүүсийн ажиллах орчин нөхцөл, Төрийн бус байгууллагын тухай хууль, Холбоо, сангийн хууль гараагүй энэ байдлаасаа болоод эрх зүйн орчны зөрчилдөөнтэй байдлууд бас бий болж байна.

Тэгэхээр бид нар Төрийн бус байгууллагын тухай хуулийг бас анхаарч, энэ зохицуулалтыг нь зөв болгохгүй бол энэ дээр бас шинэ шинэ нэр томъёогоор ингээд гарч ирээд ингээд бас ойлгомжгүй байдлууд энэ бий болгох асуудлууд бий болж байна шүү гэдгийг харж үзэж байгаа.



Тэгээд байгаль хамгаалах асуудлын хооронд ингээд салбар зөвлөлүүд их ажилладаг. Яагаад гэвэл Байгаль орчны яам өөрөө ерөнхий яам байж байгаад чиглэлийн яам болчхонгуут энэ салбарын асуудлууд орхигдсон. Тэнд ялангуяа иргэний нийгмийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа байгаль хамгаалагч нарын асуудал тэнд орж үгээ хэлдэггүйгээс нь тэр салбар зөвлөл, хороодын асуудлууд бас нэлээн тодорхойгүй байдлууд үүсгэж байна гэдэг ойлгомжгүй асуудал ингээд дундаа хаягддаг ийм асуудлууд бас гарч байна.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбоотойгоор гэрч, хохирогчийг хамгаалах механизм Цагдаагийн ерөнхийн газарт гэрч, хохирогчийг хамгаалах механизмыг бэхжүүлэх ,тэнд төсөв санхүүг нь шийдэхгүй бол энэ хамгаалалтын асуудлууд бас аягүй хүндрэх нь гээд. Хүний эрхийн Үндэсний Комисст энэ чиг үүргийг хэрэгжүүлснээс ноднин бас ялгаа байхгүй 4 хамгаалалтын арга хэмжээг авсан. Тэгэхэд хүний хүрэлцээ энэ асуудлууд бас гарч байсан гээд. Энэ асуудлыг бид нар ноднингийнхоо илтгэлээр тавьж оруулсан.

Гэтэл энэ ноднингийн илтгэлээр тавьсан асуудал бас шийдэгдээгүй. Энэ жил бид нар дахиад ингээд асуудлыг авч үзэхээр гэрч, хохирогчийг хамгаалах Цагдаагийн байгууллага дээр байгаа хэлтэстэй уялдаад тэнд хөтөлбөр баталсан. Хөтөлбөр нь 9 жил хэрэгжиж байгаа. Энэ жил дуусах гэж байгаа мөртөө ямар ч төсөвгүй 2015 онд батлагдсан төсөвгүй ингээд 9 жил явчихсан. Энэ нь яадаг вэ гэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас явуулаад Сангийн яаман дээр очихоор гарч ирдэггүй.

Гэтэл яг энэ дээр бодит байдал дээрээ тэр хөтөлбөр дээр хамгаалах байр, дэмжлэг бүх юмыг ингээд тусгана гэсэн боловч манай байдал санхүүгийн шийдэлгүйгээс энэ хөтөлбөр огт

хэрэгжээгүй ингээд дуусаж байгаа ийм дүр зурагтай байна гэж харагдаж байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ яг бүлгийнхээ саналын хэмжээнд 9 саналыг гаргуулсан. Тэн дээр бас тодотгож хэлэх асуудал. 9 санал гаргасан. Эндээс бид нар Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулах гээд 3 саналыг гаргуулсан байгаа.

Нэгдүгээрт нь юу вэ гэхээр бид нар ер нь тэр иргэний нийгмийн байгууллагын бодлогыг батлахгүй бол болохгүй нь. Иргэний нийгмийн байгууллагын бодлого өөрөө батлагдаж байж энэ нөгөөдөх төр, хувийн хэвшлийн бодлого байдаг шиг иргэний нийгмийн байгууллагын үүрэг, ач холбогдол гүйцэтгэж байгаа хүний эрх хамгаалахад ямар чухал үүрэг гүйцэтгэж байгаа вэ энэ хүмүүсийнхээ асуудлыг тодорхой болгоод, дараа нь тэр Төрийн бус байгууллагын тухай хуулийг энэ нэршил ойлголтуудыг нэг болгооч гэдэг асуудлыг тавьж байгаа.

Дараагийнх нь болохоор гэрч, хохирогчийг хамгаалах бие даасан механизм. Хүний эрх хамгаалагч ялангуяа шүгэл үлээгчийн аюулгүй байдал, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль гэхээр энийг цогцоор нь авч үзье, энэ асуудлыг нь шийдэхгүй болохгүй байна. Энэ хамгаалалтын байр, энийг шийдэхгүй болохгүй шүү гэдэг хүсэлт байсан. Бид нар байгаль хамгаалагчдад одоо түрүүнээс байгаль хамгаалах үйл ажиллагаанд хамгийн тэргүүн шугамд ажилладаг хүний эрх хамгаалагчдынхаа асуудлыг бид нар нэг мөр цэгцлэхгүй бол тэнд байгаа залгамж халаа шийдэгдээгүй, дээрээс нь тэнд байгаа хүмүүсийн ажлын байрны үнэлгээ хийгдээгүйгээс эрх зүйн байдал нь тодорхойгүй энэ асуудлыг нэг мөр цэгцлээч гэдэг ийм 3 саналыг гаргаж байгаа. Бусад бүлгийн санал авах шаардлагатай тийм 9 саналыг энэ илтгэлийнхээ бүлэг дээр ингээд тусгачихсан байгаа юм гэж хэлэх гэсэн юм.

Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Энэ асуудлаар асуух асуулттай гишүүд нэрсээ өгье.

Байхгүй байна.

Үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Байхгүй байна. Дараагийн асуудал руу орё.

**Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн хэрэгжилт, сэдвийн талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Батзэвэгийн Энхболд танилцуулна.**

Энхболд гишүүнд микрофон өгье. 1 дүгээр микрофон.

Эрхэм Хууль зүйн байнгын хорооны гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

**Б.Энхболд:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Улсын Их Хуралд өргөн барьдаг Хүний эрх чөлөөний байдлын талаар 23 дахь удаагийн илтгэлд Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн хэрэгжилтийн байдлыг авч үзлээ.

Хорих ял бол хүний эрхийг хуулиар хасаж байгаа хамгийн хүнд ялын төрөл бөгөөд гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, шударга ёсыг тогтоох үүднээс энэ төрлийн ялыг хэрэглэж байгаа ч санхүүгийн хувьд харьцангуй өндөр зардалтай, нийгэмд үзүүлэх үр нөлөө төдийлөн өндөр байдаггүй албадлагын арга хэмжээний нэг юм.

Тиймээс олон улсын чиг хандлагыг авч үзвэл хорих ялыг эцсийн арга хэмжээ болгож, нийгмийн хор аюулаар ихтэй гэмт хэрэгт зохих хугацаагаар оногдуулж гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх ажилд цогц байдлаар

анхаарал хандуулах явдал давамгайлж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Эрүүгийн хуульд хорих ялын бодлогыг энэрэнгүй ёсны зарчимд нийцүүлэн хорих ял урт хугацаатай байхаас илүү тохирсон, үр нөлөөтэй байх, ялыг ялгамжтай оногдуулах, зайлиггүй тохиолдолд эцсийн арга хэмжээ болгон хэрэглэдэг байх, аль болох нийгмээс тусгаарлахгүйгээр ялын зорилгыг хангах зэрэг үзэл баримтлалд нийцүүлэн баталсан нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн дэвшилттэй зохицуулалт болсон гэж үзэж болохоор байна.

Гэвч шүүхийн судалгаанаас үзэхэд 2020 оноос хойш хорих ял оногдуулах байдал харьцангуй буурч байгаа ч хоригдлын тоо төдийлөн буурахгүй байна. Зарим хорих ангиудад ачаалал хэтэрсэн. Өөрөөр хэлбэл, шинээр хорих ял шийтгүүлж байгаа хүний тоо суллагдаж байгаа хүний тооноос тогтмол өндөр хувьтай байна.

Тухайлбал, сүүлийн 2 жилийн дунджаар жилд 2614 хүн хорих ялаар шийтгүүлж, 1597 хүн суллагдсан байна. Энэ хандлагаас үзэхэд ойрын 10 жилд 2600 орчим хүн хорих ялаар шийтгүүлж, 16 мянга орчим хүн хорихоос суллагдах төлөв ажиглагдаж байна. Олон улсад эрх чөлөөгөө удаан хугацаанд хасуулсан буюу хорих ял эдэлж буй байдлыг байдлыг 100 мянган хүнд ноогдох хоригдлын үзүүлэлтээр харьцуулан үздэг нийтлэг жишигээр авч үзвэл 2023 оны байдлаар Монгол Улс 100 мянган хүн амд ноогдох хоригдлын тоо 129 гэсэн үзүүлэлттэй байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Хорих ял шийтгүүлсэн хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 82 орчим хувийг хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, мөн

өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Ялангуяа өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн хүн хоригдлуудын дунд 2021 онд 23.5хувь, 22 онд 34.7 хувь, 23 онд 34.8 хувийг эзэлж байгааг анхаарах шаардлагатай юм.

Учир нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь ихэвчлэн хүн амын амьжиргааны түвшин, ядуурал, ажилгүйдэл, боловсролын түвшинээс ихээхэн шалтгаалдаг бөгөөд нийт хүн амын амьдралын чанар, орлогын түвшнийг нэмэгдүүлэх, боловсролын чанарыг дээшлүүлэх замаар эдгээр хоригдлын тоог бууруулах боломжтой гэдгийг анхаарах шаардлагатай.

Өөрөөр хэлбэл, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хувь хэмжээ өндөр байгааг анхаарах шаардлагатай байна. Мөн хоригдлын тоо буурахгүй байгаа өөр нэг хүчин зүйл нь хорихоос суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэж, хорих ялаар шийтгүүлж байгаа явдал юм.

Ялангуяа суллагдсанаас хойш 1 жилийн дотор дахин гэмт хэрэг үйлдэх тохиолдол хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа нь хорих ялын үр нөлөө бодитой байгаа эсэх, гэмт хэрэг үйлд үйлдэж буй нийгэм, эдийн засгийн шинжтэй шалтгаан, нөхцөлийг арилгаж чадаж байгаа эсэх, хорихоос суллагдсан хүнд дэмжлэг үзүүлэх бодлого үр нөлөөтэй байгаа эсэх асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Комиссоос хийсэн судалгаагаар дахин гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн тохиолдолд 2021 онд 52.4 хувь, 2022 онд 53.8 хувь, 2023 онд 55.1 хувь. Үүнээс хорих ял эдлээд суллагдсан хүмүүсээс дахин гэмт хэрэг үйлдэх тохиолдол 26 орчим хувийг эзэлж байна.

Удаан хугацаанд нийгмээс тусгаарлагдаж, хөдөлмөр эрхлэх, эрүүл

мэндийн тусламж, үйлчилгээ авах, сурч боловсрох, цалин хөлсөө захиран зарцуулах зэрэг өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг хорих ялын дэглэм, зэрэглэлд нийцүүлэн хэрэгжүүлдэг онцлогтой холбоотойгоор суллагдсаны дараа нийгмийн харилцаанд бие даан оролцоход хүндрэлтэй байдаг асуудлыг анхаарч үзэх нь чухал байна.

Комиссоос хийсэн судалгаагаар хорих ял эдлээд суллагдсан хүн хуулиар тодорхойлсон нийгмийн халамж авах, шаардлагатай баримт бичгээ бүрдүүлэх, шинээр авах, ажил хөдөлмөр эрхлэх боломж хомс, нийгмээс ялгаварлан гадуурхагддаг, гэр бүлийн харилцаа хөндийрдөг, өөрийн гэсэн орон байргүй, ажил орлогогүй гэсэн шалтгаанаар дахин гэмт хэрэг үйлдсэн байх хувь хэмжээ багагүй хувийг эзэлж байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс хүндрүүлэхгүй байх( зан үйлийн сөрөг өөрчлөлтөөс хамгаалах ажил нь хоригдлыг хорих байгууллагад хүлээн авахаас эхлэн ял эдлэх бүхий л хугацааг хамарч суллагдахад бэлтгэх, сулласны дараах үйл явдлаар дуусгавар болдог цогцолбор шинжтэй арга хэмжээ гэдгийг эргэн харах шаардлагатай байна.

Монгол улсад хоригдлыг нийгэмшиүүлэх, хорихоос суллагдахад бэлтгэх, суллагдсаны дараа хяналт тавих, нийгэм, эдийн засгийн хувьд тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болохоор байгаа ч хорих ангийн санхүүгийн нөөц бололцоо дутмаг, нийгмийн ажил явуулах арга барил шинэчлэгдээгүй, суллагдсаны дараа дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээсэн байгууллагуудын хамтын ажиллагаа сул, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас хорих ял шийтгүүлсэн хүнийг нийгэмшиүүлэх, суллагдсан хүнд дэмжлэг үзүүлэх бодлого туйлын хангалтгүй байгааг эндээс харж болохоор байна.

Нөгөө талаар хоригдлыг нийгэмшиүүлэх, нийгэмд дасан зохицоход

нь дэмжлэг үзүүлэх бодлого зөвхөн хорих ял эдлүүлэх явцад, эс үгүй бол суллагдах дөхсөн хоригдолд хамааралтайгаар хэрэгжиж байгаа ба суллагдсаны дараа дэмжлэг үзүүлэх албан ёсны тогтолцоо бүрдээгүй нь хорих ялын үр нөлөөг сулруулж, хувь хүн нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж байгааг анхаарах нь зүйтэй.

Иймд Хүний эрхийн Үндэсний Комиссоос Улсын Их Хуралд дараах 5 асуудлыг шийдвэрлүүлэхээр санал болгож байна.

Нэгдүгээрт, Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг нийгэмд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх механизмыг олон улсын туршилагад нийцүүлэн бий болгох. Ингэхдээ Төрийн бус байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх бодлого эрх зүйн орчныг бүрдүүлэх.

2.Хорих ял шийтгүүлсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүйгээр ялын зоргыг хангах ажлын бодит үр нөлөөг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх.

3.Хорих ангийн тоог бууруулах урт хугацааны зорилгын үүднээс хорих ангийг дагнасан сургалт, үйлдвэрлэлийн хэлбэрээр зохион байгуулах бодлого гаргаж хэрэгжүүлэх.

5.Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 20 онд батлагдсан хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөрт оролцогч талуудын үүрэг, оролцоог шинээр тодорхойлох, хэрэгжилтийг нь хангах, мөн Боловсрол, шинжлэх ухааны яамны чиг үүргийг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газарт чиглэл өгөх.

6-д.Хоригдлын хөдөлмөр эрхлэх нөөц, сонирхол, хэрэгцээг тодорхойлж, түүнд тохирсон мэргэжил, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үүнд шаардагдах санхүүжилтийг

шийдвэрлэх шаардлагатай байгааг танилцуулж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Танилцуулсан асуудалтай холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна. Тэгвэл дараагийн асуудалдаа орёе.

**Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйл, шийдэл сэдлийн талаарх** Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ганбатын Нарантуяа танилцуулна.

Нарантуяа гишүүний микрофон өгье. 1 дүгээр микрофон.

**Г.Нарантуяа:** Хууль зүйн байнгын хорооны даргаа,

Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх хүчин зүйлийн талаар Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэлд оруулсныг танилцуулъя.

Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс улс төрд оролцож чадаж байна уу? Сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлж чадаж байна уу гэдэг асуултад их бодоод байхгүйгээр чадахгүй байна гэсэн хариулт гарна.

Яагаад Хүний эрхийн Үндэсний Комиссоос хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхтэй холбоотой асуудлыг тусгайлан илтгэхээр зорьсон юм бэ гэдэг нь бол 2 учир шалтгаантай.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, Улс төрийн

намуудын тухай хууль, Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг шинэчлэн найруулж, нийгмийн бүлгүүдийн төлөөллийг улс төрд оролцоог нэмэгдүүлэх энэ бодлогын хүрээнд авч байгаа энэ бодлогын арга хэмжээ хэр үр нөлөөгөө өгч чадах юм бэ гэдэг дээр бол Хүний эрхийн Үндэсний Комисс байр сууриа илэрхийлэхийг зорьсон.

Хоёрдугаар асуудал нь. Ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тунхаглал бол өнөөдөр Монгол Улсад эрхийн тунхаглал, бодит байдал хоёр хоорондоо ямар хол зөрүүтэйг харуулж болох ийм тод томруун салбараа.

Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх бусад иргэдийн нэгэн адил амьдрах эрхтэй гэж бид 2008 оноос бол идэвхтэйгээр ярьсан. Гэхдээ өнөөдөр бодит байдал, тунхаглал хоёр ямар хэмжээний зөрүүтэй байгаа вэ гэдгийг бол бид их бодоод байх шаардлагагүйгээр ойлгомжтой харж байгаа асуудал юм.

Тэгэхээр ийм нийгмийн тусгаарлагдсан бүлгүүдийн асуудлыг хэрхэн шийдэх юм бэ? Бодлогын шийдлийг хэрхэн гаргах юм бэ гэдэг дээр харах өнцгийг сануулах нь бол Хүний эрхийн Үндэсний Комиссын үүрэг гэж үзсэн учраас энэ сэдвээр энэ удаагийн илтгэлийг бичсэн юм.

Ямар үр дүн гарч байна вэ? Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох сонгогдох эрхийн хэрэгжилт ямар байна вэ? Өнөөдөр Монгол Улсад 115 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа. Үүний 100 мянга орчим нь бол Үндэсний статистикийн газрын тоогоор 100 мянга орчим, Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн мэдээллээр бол 90 мянга орчим. Өнгөрсөн сонгуульд бол 80 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс оролцож, саналаа өгсөн байгаа.

Санал өгөх тухайд бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 80 орчим хувь нь саналаа өгч чадаж байна. Гэхдээ өнгөрсөн хугацаанд зохион байгуулагдсан

Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн, Орон нутгийн 7 удаагийн сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй 7 хүн нэр дэвшүүлж байсан. Ямар ч хүн сонгогдож байгаагүй. Харин Налайх дүүргийн иргэдийн хуралд одоо хөгжлийн бэрхшээлтэй хүн төлөөлөгчөөр ажиллаж байгаа.

Тэгэхээр сонгох, сонгогдох эрх бидний бодлогын түвшинд авч байгаа арга хэмжээний бодит үр дүн бол хангалтгүй, огт хангалтгүй байгаа юм.

Яагаад өнөөдөр Улс төрийн намуудын тухай хуулиар эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нэр дэвшүүлсэн улс төрийн намууд тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг авах хөшүүргийг бий болгосон. Үүнийг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн чухал механизм үр дүнгээ өгнө гэсэн хүлээлттэй байгаа.

Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэж бид ямар хүмүүсийг хэлж байна вэ гэдэг дээр дээр бол Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ жил хийсэн судалгаа анхаарлаа хандуулсан юм.

Би олон статистик тоо баримтыг илтгэлд тодорхой орсон байгаа учраас ярих шаардлагагүй. Ганцхан тоо баримтыг та бүхэнд дурдаж хэлэхийг хүссэн юм. Тэгэхээр өнөөдөр бид нар хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрх гэр бүл амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур амьдралтай, хөгжлийн бэрхшээлтэй хүн өнөөдөр улс төрийн чөлөөт хүсэл зоригоо илэрхийлээд улс төрийн сонголт хийнэ гэхээсээ илүүтэй өдөр тутмын амьдралдаа бие даасан шийдвэр гаргаж дадаагүй ийм хүмүүсийн тухай ярьж байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023 онд 1965 онд байгуулагдсан тусгай сургуулиудад шалгалт хийсэн. 116, 29 дүгээр сургууль маш их асуудал дагуулдаг сургуулиуд. Хүний эрхийн Үндэсний

Комиссын байнгын хяналтад байдаг. Үндсэндээ 65 жил үйл ажиллагаа явуулж байгаа хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийг сургах тусгай сургуулиуд бол өнөөдрийг болтол хүн сургах, сургалт явуулах арга барилаа олоогүй байгаа. Тэгш хамран сургах хөтөлбөр гэж байна Боловсролын багц хууль шинэчлэн найруулагдсантай холбоотой энэ хуулийн үндсэн амин сүнс концепц болж байгаа асуудал байгаа. Тэгэхээр өнөөдрийг болтол 65 жилийн туршид хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийг сургах аргачлалаа олоогүй байхад тэгш хамран сургах боловсролыг бид яаж хэрэгжүүлэх вэ гэдэг бодлогын асуудал тавигдаж байгаа юм.

Тэгэхээр түрүүний миний та бүхэнд танилцуулахыг хүссэн тоо баримт Хүний эрхийн Үндэсний Комиссын судалгааг МУИС-ийн Улс төрийн танхим, хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн байгууллагууд, ялангуяа энд сонгуульд оролцож явсан хүмүүсийн оролцоотойгоор бол хийсэн судалгааныхаа үр дүнг бас нэлээн шинжлэх ухаанч арга барилтай болсон гэж үзэж байгаа.

Судалгаанд оролцсон хөгжлийн бэрхиээлтэй хүмүүс Монгол улсын дундаж өрхөөс 47 хувиар их эрүүл мэндийн зардал гаргаж, боловсролд 73 хувиар бага зарцуулалт хийж байгаа. Хүнсний бүтээгдэхүүний зардал улсын дундажтай харьцуулахад 18 хувиар хувиар бага, боловсрол зарцуулах төсөвгүй шахам байгаа нь хөгжлийн бэрхиээлтэй хүмүүс бие даан нийгмийн харилцаанд оролцох, бусадтай харилцах, бие даан шийдвэр гаргах чадвар эзэмшихэд маш том хязгаарлалт болж байгаа. Энэ судалгаанд оролцсон хүмүүсийн 30 орчим хувь нь хэзээ ч санхүүгийн өөрөө мэдэж захиран зарцуулаагүй гэсэн.

Тэгэхээр бид нар сонгуулийн байрыг хүртээмжтэй болгоно, хөгжлийн бэрхиээлтэй хүмүүсийг нэр дэвшүүлсэн улс төрийн намуудад санхүүгийн дэмжлэг олгоно гэдэг энэ арга хэрэгсэл

маань бол өнөөдөр хөгжлийн бэрхиээлтэй хүмүүсийн, дийлэнх хөгжлийн бэрхиээлтэй хүмүүсийн бодит амьдралаас хол байгаа юм гэж Хүний эрхийн Үндэсний Комиссоос дүгнэж байна.

Тэгэхээр яаж энэ асуудлыг бид нар өнөөдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд хүүхдийн асуудал, гэр бүлийн хүчирхийллийн асуудал, хүчирхийллийн асуудал, хорих ял эдлүүлээд суллагдсан хүмүүсийн асуудлыг ярьж байна. Энэ дээр маш тод харагдаж байгаа хоёр асуудал бол монгол хүний өрхийн орлогыг нэмэгдүүлэхгүйгээр, боловсролын чанарыг нэмэгдүүлэхгүйгээр нийгмийн бодлогод ямар ч өөрчлөлт гарахгүй гэдэг ийм дүгнэлтийг бид дуу нэгтэйгээр хэлж байна.

Тэгэхээр хөгжлийн бэрхиээлтэй хүний амьдралын нөхцөл байдал гэдэг бол нийгэм, улс төр, хувь хүний олон хүчин зүйлсийн нөлөөгөөр үүссэн ийм үзэгдэл юм. Нийгмийн энэ үзэгдэлд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлоод, нэн тэргүүнд энэ улс орны хэмжээнд авах боломжтой бодлогын асуудлыг, аль эсвэл өргөн хүрээнд авах ёстой ажил асуудлыг сонгож, бодлогын дарааллыг зөв гарга гэж амжилттай хэрэгжүүлэх нь бол өнөөдөр ямар ч салбарт тулгамдаж байгаа үндсэн асуудал учраас бид энэ бас хөгжлийн бэрхиээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоо сэдвийн хүрээнд бас хөндөхийг зорьсон том макро түвшний бодлогын асуудал нь энэ юм.

Таван саналыг гаргалаа. Гурав нь Улсын Их Хуралд хандсан байгаа. Хөгжлийн бэрхиээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх дэмжих талаар, хоёр нь бол Засгийн газарт чиглэсэн ийм таван санал байгаа.

Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай конвенцод Монгол Улс 2009 онд нэгдэж орсон. Энэ конвенцын 33 дугаар зүйлд Хөгжлийн бэрхиээлтэй хүний хэрэгжилт, эрхийн хэрэгжилтэд хяналт тавих хараат бус механизмыг

бий болгох үүргийг бол оролцогч улсууд хүлээсэн байгаа. Өнөөдрийг болтол бол Монгол Улс хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих механизмыг тодорхойлж, томьёолж тогтоогоогүй байгаа юм.

Тэгэхээр энэ хяналт тавих бүтцийг тогтоон хуульчилъя. Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийг хангах үүргээ биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд оноо оногдуулах хариуцлагыг Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хуулиудад нарийвчлан тусгах хариуцлага тооцох механизмыг нь тодорхой болгох эхний санал байна.

Хоёр дахь санал нь бүх шатын сонгуульд нэр дэвшиж буй хөгжлийн бэрхиээлтэй нэр дэвшигчид мэдээж санхүүгийн дэмжлэггүйгээр бол Хөгжлийн бэрхиээлтэй хүн битгий хэл би өнөөдөр сонгуульд нэр дэвшүүлж чадахгүй. Тийм учраас санхүүгийн дэмжлэг бол үнэхээр хөгжлийн бэрхиээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоог нэмэгдүүлнэ гэж байгаа бол хөгжлийн бэрхиээлтэй хүмүүст чиглэсэн санхүүгийн дэмжлэгийг гарцаагүй бий болгох шаардлагатай.

Хөгжлийн бэрхиээлтэй нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдлоо гэж бодоход бол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд чуулганы танхимтай холбоотой, хуралдааны дэгтэй холбоотой өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай. Энэ саналыг Хүний эрхийн Үндэсний Комисс Улсын Их Хуралд хандаж гаргаж байна.

Засгийн газрын түвшинд хоёр санал.

Хөгжлийн бэрхиээлтэй хүмүүс бие дааж шийдвэр гаргах, сонгох, өнөөдөр би ямар хоолоо идэх вэ гэхээсээ эхлээд намайг төлөөлөх төрийн түшээ хэн байх вэ гэдгээ сонгох, эргэцүүлэх энэ боломжийг олгох олон арга хэмжээ авах шаардлагатай.

Гэхдээ хамгийн нэгдүгээрт нь бол хувь хүн, та бол хувь хүн, бие даасан үзэл, сонголтоо хийх ёстой гэдэг энэ дадал хэвшил, ойлголтыг төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг Хөгжлийн бэрхиээлтэй хүний хөгжлийн төв, Насан туршийн суралцахуйн төв гэж Боловсролын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүрээнд байгуулагдсан механизмууд байгаа. Өнгөрсөн хугацаанд Засгийн газраас нэлээд их хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн. Энэ төвүүдээр дамжуулж явуулах шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхиээлтэй хүмүүс, ахмад настан гээд бас дэмжлэг шаардлагатай хүмүүсийн асуудлыг шинэ технологийн тусламжтайгаар бол шийдэх боломжтой. Тэгэхээр Монгол Улсын цахим хөгжлийн бодлогод хөгжлийн бэрхиээлтэй хүмүүсийн амьдралын чанар, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх асуудлыг тусгайлан анхаарч тусгаарай гэсэн ийм саналыг Хүний эрхийн Үндэсний Комисс гаргаж байна. Танилцуулж дууслаа.

Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Танилцуулсан асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Би үг хэлнэ. Энд дээр Их Хуралд хандаж гаргаж байгаа энэ саналуудыг би зөв санал байна гэж бодож байна. Ялангуяа энэ хөгжлийн бэрхиээлтэй иргэдийг хэрэв нэр дэвших тохиолдолд ямар нэгэн дэмжлэг үзүүлэх ёстой. Тэгэхгүйгээр энд шударга өрсөлдөөний орчин бүрэлдэхгүй гэдэг энэ санал их зөв санаа явж байгаа юм байна. Би харин энэнтэй холбогдуулаад эхний ээлжид, одоо нэгэнт хугацаа их богинохон үлдчихсэн байгаа учраас энэний дараа

бүүр яг энэ дээр онцгойлоод яриад сууя гэж бодож байна.

Яагаад гэвэл үүний чинь дагуу хийх ажлын арга хэмжээнүүдийг тусгасан тогтоол гарна. Тэр дээр үүнийг бас тусгах талаар ярья. Миний бодож байгаагаар хамгийн эхний ээлжид хийх юм юу гэвэл Хүний эрхийн Комиссын яг энэ асуудал эрхэлсэн энэ тайлангийн энэ хэсгийг боловсруулахад оролцсон хүний хувьд та ер нь бүх улс төрийн намуудад ийм зөвлөмж харин би явуулж болох юм байна гэж бодож байна.

Яагаад гэвэл энийг төр, хувийн хэвшил, улс төрийн намууд бүгд Хүний эрхийн Комиссын гишүүний энэ зөвлөмжийг авч үзэж, хэрэгжүүлэх ёстой, үүрэгтэй. Тэр үүднээсээ би бас энийг явуулбал зүгээр байж магадгүй гэж бодож байна. Тэгэхдээ би бол одоо шууд энийг таны хэлсэн саналуудын хариуд миний төрж байгаа бодлыг л хэлж байна шүү дээ. Үүнийг энэ хурлын дараа нэгэнт тогтоол тусгайлан гарах учраас энэнтэйгээ холбогдуулаад би бас ярьж, зөвлөлдье гэж бодож байна.

Ингээд Хүний эрхийн төлөв байдлын талаарх тайланг 7 хэсгээс бүрдсэн энэ тайланг хэлэлцлээ. Тэгэхлээр Эрүүл, аюулгүй орчинд амьдрах хүний эрхийн тухай, боловсролтой холбогдсон боловсрол авах энэ эрхтэй холбогдсон хэсгийг хэлэлцлээ. Хүүхдийн эрхийн асуудлаарх хэсгийг хэлэлцлээ. Гэр бүлийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлын талаарх нөхцөл байдлын талаарх хэсгийг хэлэлцлээ. Иргэний нийгэм, байгаль орчны чиглэлийн чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилтийн талаарх хэсгийг бас хэлэлцлээ. Хорих ял эдлээд суллагдсан хүний эрхийн хэрэгжилтийн асуудлыг бас хэлэлцлээ. Ингээд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх хэсгийг тус тус хэлэлцлээ. Ингээд 7 хэсгээс бүрэлдсэн энэ 7 хэсгийг ямар ч гэсэн энэ хэсгүүдээ хэлэлцлээ.

Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг хэлэлцэж дууслаа.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүдэд баярлалаа.

14.35 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР